

## ИЛ ХААНТ УЛСЫН ВЕЗИРИЙН ТОГТОЛЦООНЫ ЗАРИМ ОНЦЛОГУУД ХИЙГЭЭД МОНГОЛ ВЕЗИР БУХА ЧИНСАН

Д.АНХБАЯР

**Товч агуулга:** Их Монгол Улсын хаан Мөнхийн дүү Хүлэгү 1256 онд Ил хаант улсыг байгуулсны дараа улс орны иргэний удирдлагыг Хорасаны диванатын загвараар байгуулсан билээ. Уг байгууллагын онцлог ёсоор иргэний удирдлага везаретын толгойд Иран гаралтай түшмэд, санхүүчид гарсан. Гэвч везарет байгуулагдсан цагаас эхлэн улс төр, цэргийн эрхтэн болох Монгол ноёдтой гүн зөрчилд орж эхэлсэн бөгөөд уг хоёр хүчний тэнцвэрийг хэрхэн хангаснаас Ил хаадын улс төр, нийгмийн амьдрал шалтгаалж байв. Уг өгүүлэлд Ил хаадын везирийн тогтолцооны зарим онцлогыг ерөнхийлөн авч үзсэний дээр Аргун ханы үед Монгол ноёдын нэгэн болох Буха чинсаны везирийн тогтолцоог удирдсан арга ажиллагаа, үр дүнг тусгайлан судалсан болно.

**Түлхүүр үг:** Ил хаант улс, везир, сахиб-и диван, Аргун хан, Монгол ноёд, Буха, хүчний тэнцвэр.

### *1. Ил хаант улсад везирийн тогтолцоо бүрэлдсэн нь*

Их Монгол Улсын хаан ширээнд Тулуйн ахмад хөвүүн Мөнх 1251 онд заларсны дараа нийт эзэмшил нутгийг Тулуйн гэр бүл төвтэй захиргаанд оруулах зорилго бүхий улс төр, эдийн засаг, соёл зэрэг олон салбарыг хамарсан шинэчлэл хийсний нэгэнд өөрийн дүү Хүлэгүг өрнө зүгт томилон салбар улс байгуулсан явдлыг дурдаж болно.

Хүлэгү хан газарзүйн хувьд Иранд төвлөрсөн Ил хаант улсыг байгуулах явцад өөрийн засаглалыг хүлээн зөвшөөрүүлэх алхамыг хийж эхэлжээ. Тэрээр төрийн тэргүүн хүнд байх харизмын бүхий л шинжийг агуулсан нэгэн<sup>1</sup> хийгээд

<sup>1</sup> Жувейни Хүлэгү нь бусад хан хөвүүдээс төр удирдах ухаан хийгээд их хааны шинжийг илүү агуулсан нэгэн гэдгийг онцлон тэмдэглэжээ: “*Pādshāh-e rū-ye zamīn Mankū Qāān chūn āz shemāyil berāder-e xūvīsh Hūlāgū mehāyil-e jahāndārī mī-dīd va āz ‘azāyīm-e ū merāsīm-e jahāngīrī tafarras mī-namūd*”. “Ертөнцийн падишах Мөнх хаан бээр өөрийн бүх дүү нараас Хүлэгүг ертөнцийн эзэн болох хүслийг олж харсан бөгөөд түүний гайхалтай чадвар, ертөнцийг атгах үйлсэд нь илгээсэн болой”. ‘Alā’ āl-Dīn ‘Atā Malek Jūwaīnī. *Tārīx-e jahān gūshā-yī*. Tashīh Muhammed bin ‘Abd āl-Vahāb Qazvīnī. J.III, Tehran., 1385, 972. Энэхүү өгүүлэмжийг Рашид Ад-Дин “Судрын

Их хуралдайгаас баруун зүгийн орнуудыг удирдах эрхийг авсан<sup>1</sup> хэдий ч өөрийн засаглалыг Ойрх дорнодын бүс нутагт хүлээн зөвшөөрүүлэх шаардлагатай байлаа. Үүний тулд Хүлэгү хан 1255 оны намар Кеш мөрний эрэгт байрлах үедээ Аргун ах тэргүүтэй Хорасаны диванатын удирдагчдыг дуудан Ираны эрхийг гартаа оруулав<sup>2</sup>. Дараа нь тэрээр Жейхун мөрнийг гатлах үед Анатолигоос Изз Ад-Дин болон Рукн Ад-Дин султан, Фарсаас Атабек Саади Музаффер, Ирак, Хорасан, Азербайжан, Арран, Ширван болон Гүржээс орон нутгийн хахим-захирагч нар ирж бараалхан дагаар орсноо илэрхийлцгээв<sup>3</sup>. Хүлэгү хан ийнхүү бүс нутагт тогтоосон засаглалаа зарлан 1256 онд хан ширээнд суух ёслол үйлдсэний дараа улс орны захиргаа, иргэний хэргийг эрхэлсэн албыг хуучин Хорасаны диванатын албан хаагчид болох Карай Малек, Ахмед битигчи болон түүхч Ала Ад-Дин Ата Малек Жувейни зэрэг хүмүүсээс бүрдүүлсэн нь<sup>4</sup> байлдан дагууллын үеийн түр үүрэгтэй байгууллагын шинжтэйгээр 1263 он хүртэл үргэлжилжээ. Хэдийгээр 1256-1262 оны хооронд улсын везир буюу *vazîr va mudabbîr* үүрэг бүхий албан тушаалыг Сейф Ад-Дин Бахадир бин Абдуллах Хорезми хашиж байсан боловч Хүлэгү ханы нэрийн өмнөөс зарим эвдэрсэн хот болон байгууламжын бүтээн байгуулалт, шашны үйл хэрэг болон цэргийн хэрэгт зөвлөх зэрэг идэвхтэй бус үүрэг гүйцэтгэж байсан тул сонгодог утгаар везир буюу Сахиб-и диваны шинжтэй байж чадаагүй ажээ<sup>5</sup>.

Шинэ тутам байгуулагдсан Ил хаант улс нь улс төр, цэргийн хувьд хүчирхэгжин байлдан дагууллыг амжилттай явуулж байсан боловч эзэмшлийн бүс нутагт эдийн засгийн томоохон бэрхшээлүүдтэй нүүр тулгарч эхлэв. Үүний гол шалтгаан нь 1230 оноос эхэлсэн Хорезмын Желал Ад-Дин султан ба Монголчуудын хооронд явагдсан дайн ялангуяа Азербайжаны бүс нутгийн эдийн засгийн амьдралд сөрөг нөлөө үзүүлжээ. Дээр нь 1262-1263 оны хоорондох Ил хаант улс ба Алтан ордны улсын дайнаас болж хойд Азербайжанд эдийн засгийн хомсдол гаарчээ. Эдгээр шалтгаануудын улмаас Хүлэгү ханы үеийн Азербайжанд нийт тариалангийн талбайн дөнгөж 10 хувь нь л ашиглагдаж байв<sup>6</sup>. Ил хаадын улсын чухал түшиц газар

---

чуулган”-д давтсан байдаг: - Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. Tashîh Muham-med Rûshan, Mustafî Mûsavî. J.II, Tehran., 1383, 974.

<sup>1</sup> Жувейнигийн өгүүлснээр Их хуралдайгаас Хүлэгүд хан цол өргөмжилсөн аж. ‘Alâ’ âl-Dîn ‘Atâ Malek Jûwaînî. *Târîx-e jahân gûshâ-yî*. J.III, 1385, 972.

<sup>2</sup> ‘Alâ’ âl-Dîn ‘Atâ Malek Jûwaînî. *Târîx-e jahân gûshâ-yî*. J.III, 1385, 981.

<sup>3</sup> ‘Alâ’ âl-Dîn ‘Atâ Malek Jûwaînî. *Târîx-e jahân gûshâ-yî*. J.III, 1385, 979.

<sup>4</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 980.

<sup>5</sup> Ankhbayar Danuu. *Îlhanlı Devleti'nde Vezaret*. Yayınlanmamış Doktora Tezi, Ankara Üniversitesi Sosyal Bilimler Enstitüsü Tarih Bölümü, Ankara., 2016, s.136-142.

<sup>6</sup> *Azərbaycan tarixi (XIII-XVIII əsrlər)*, C.III, “Elm”, Bakı: 2007, 48.

болох Хорасанд ч байдал сайнгүй байв. Тухайлбал, 1256 оны үест Хабушан хотын бүх байшингууд эвдэрч сүйрэн, усан сувгууд хатсанаар ард түмний амьдрал ихэд доройтжээ<sup>1</sup>. Ил хаант улсын баруун хэсэгт байх үржил шимт Анатолийн хойгийн байдал ч улам муудсаар байв. 1250-иад оноос эхлэн Анатолийн Селжүкийн улсад эдийн засгийн хямрал гаарч эхэлжээ. Ил хаадын хувааж захирах бодлогын хүрээнд ах дүү гурван султаныг зэрэг өргөмжилснөөр тэдний зардал, ордны зугаа цэнгэл хийгээд Монголчуудад төлж асан татварын хэмжээ ихэссэн зэрэг нь уг хямралыг өдөөгч үндснэ хүчин зүйл болжээ. Үүний дээр 1256 онд Байжу ноён Султанөнүгийн тулалдаанд ялан улмаар Анатолийн хойгт цэргээ байрлуулан ба цэргийн зардлыг ялагдсан Селжүкийн султануудаас дайчлан гаргуулах болсон нь улам нэрмээс болов. Энэ нөхцөлд Селжүкийн султанууд Хүлэгү ханаас үе үе зээл авах замаар нөхцөл байдлыг аргацаах бодлого явуулж байлаа<sup>2</sup>. Армян болон Гүржид Монголчуудын явуулсан хүн амын тооллого болон татварын шинэчлэл нь бүс нутгийн ард түмний гомдол дургүйцлийг төрүүлэх болов. Монголчуудын тогтоосон татварын хэмжээ нь өмнөх үеэс ихэд нэмэгдсэн тул татвар хураах үед ардууд ихэд шахамдах болжээ. Түүгээр ч үл барам татварын өрөө төлөхийн тулд үр хүүхдээ зарах ч тохиолдол гарч байв. Үүний тул худалдаачид болон гар урчууд дампуурах үзэгдэл газар авав<sup>3</sup>. 1251 онд Армян болон Гүржид болсон царцааны нүүдлийн улмаас бүхий л ургац сүйдсэн бөгөөд учирсан хохирлыг арилгахад нэлээд хэдэн жилийн хугацаа шаардагдахаар байв<sup>4</sup>.

Үүнээс гадна бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдөж асан гувчуур (qobchur)-ын системд ч зарим сөрөг байдал үзэгдэж эхлэв. Учир нь баячуудын орлогыг тус бүрээр нь ангилалгүйгээр зөвхөн жилийн нийт орлого хийгээд хөрөнгийн хэмээг тооцон гувчуур онооход төлөх хэмжээ маш бага хэмжээтэй болж байв. Үүнээс гадна уг жилд баяны орлого нь нэмэгдлээ гэхэд түүнд нь тохируулсан нэмэлт гувчуур үгүй байв. Үүний улмаас хуучин 500 динарын гувчуур төлж байсан этгээд 10 динар төлөх болжээ. Өөрөөр хэлбэл гувчуурын тогтолцоо нь баячуудад ээлтэй, ядууст хохиролтой болж ирсэн тул олон нийт ч эсэргүүцэх хандлагатай болж ирэв. Аргун ах энэ байдлыг тусгайлан судалж Хархорумд мэдээлсний дүнд гувчуурыг тогтмол

<sup>1</sup> 'Alâ' âl-Dîn 'Atâ Malek Jûwaîni. *Târîx-e jahân gûshâ-yî*. J.III, 1385, 986.

<sup>2</sup> İlhan Erdem, "Türkiye Selçuklu-İlhanlı İktisadî, Ticarî İlişkileri ve Sonuçları", *Ankara Üniversitesi Dil, Tarih ve Coğrafya Fakültesi Tarih Bölümü Tarih Araştırmalar Dergisi*, sayı 33, cilt 21, Ankara., 2003, 50-51.

<sup>3</sup> Müellif Kiragos. Ermeni Müellifi Kiragos'un Vakayinamesi. (Edt. Hasan Oktay). *Ermeni Kaynaklarında Türkler ve Moğollar*. İstanbul., 2007, 80.

<sup>4</sup> Aknerli Grigor. *Okçu Milleti'nin tarihi*. Çeviren Hrant Andresyan. İstanbul., 1954, 24; Galstyan A.G. *Ermeni Kaynaklarına göre Moğollar*. Çeviren İlyas Kamalov, İstanbul., 2005, 45, 67

хэлбэрт оруулан баян хүнээс 500 динар, ядуусаас 1 динар болгон татварлахаар тогтож байв<sup>1</sup>.

Ийнхүү улсын хэмжээнд иргэдийн амьдралд сөргөөр нөлөөлсөн эдийн засгийн хямрал нүүрлэсний улмаас зарим газарт бослого тэмцэл ч гарах болов. Мосулын захирагч Салих Исмайлйн 1261 онд гаргасан бослого жил орчим үргэлжилсэн<sup>2</sup> бол Гүржийн V Давид монголчуудын тогтоосон татварын шинэчлэлийг эсэргүүцэн бослого гаргасан боловч 1259 онд Аргун ах даржээ<sup>3</sup>.

Хүлэгү хан үүссэн нөхцөл байдлыг шийдэхийн тулд дан ганц Монгол ноёд удирдагчдын хүч хангалтгүй бөгөөд орон нутгийн ноёд, албан хаагчдыг ашиглахын ач холбогдлыг мэдэрч байв. Өөрөөр хэлбэл, Ил хаант улсад иргэний шинжтэй бодлого явуулах албыг улс төр, цэргийн байгууллагуудаас тусгаарлах нь нэн чухал асуудал болов. Хүлэгүг баруун зүг мордоход Мөнх хааны өгсөн захиас сургаалд татварын хэмжээг багасган ард иргэдийг амаржуулах хийгээд сүйрч эвдэрсэн хот балгадыг засаж сэргээхийн ач холбогдлыг дэлгэрэнгүй өгүүлсэн байдаг<sup>4</sup>. Энэ нөхцөлд Хүлэгү ханы дэргэд буй Иран зөвлөхүүд өөрсдийн байр суурийг дээшлүүлэх хийгээд төрийн бүтцэд Иран-Исламын төрийн уламжлалт элементийг багтаах үйл ажиллагааг идэвхтэй явуулж байсны жишээнд Хаже Насир Ад-Дин Тусигийн өргөн барьсан Иранд хэрхэн төр барих тухай тайлан-илтгэлийг дурдаж болно<sup>5</sup>. Уг тайлан-илтгэлд юуны өмнө төрийн байр суурийг бэхжүүлэхийн тулд хууль, эрхийн бичгүүдийг (*resm va âyîn*) өөрчилж үл болохын чухлыг онцлон тэмдэглэжээ<sup>6</sup>. Хаже Насир Ад-Дин Тусигийн энэхүү санал нь үе дамжин үл өөрчлөгдөх Их Засаг хууль Ил хаант улсад ч жинхэнэ утгаараа хэрэгжихийг баталгаажуулсан хэрэг байв. Төрийн үндсийг бүрдүүлэгч гол хүчин нь сэлэмт (*shamshîr*), үзэгт (*qalam*) хоёроос бүрдэх бөгөөд сэлэмт хүчний гарт цэргийн хэрэг, үзэгт хүчний гарт бичгийн хэрэг төвлөрнө хэмээн тэмдэглэсэнээр<sup>7</sup> төрийн хэргийг цэргийн хийгээд иргэний удирдлага хэмээн тусгаарлах санааг гаргасан байна. Үзэгтэн хэсгийг дотор нь шашны мэргэд (*âhl-e dîn*), бичгийн мэргэд (*âhl-e ‘ulamâyî*), төрийн түшмэд (*vazîrân va yârgûchîyân va navîsandegân*),

<sup>1</sup> ‘Alâ’ âl-Dîn ‘Atâ Malek Jûwaînî. *Târîx-e jahân gûshâ-yî*. J.II, 1385, 746.

<sup>2</sup> Bertold Spuler. *Iran Moğolları: Siyaset, İdare ve Kültür (İlhanlılar Devri 1220-1350)*. Çeviren Cemal Köprülü, TTKY, Ankara, 1987, 74

<sup>3</sup> ‘Alâ’ âl-Dîn ‘Atâ Malek Jûwaînî. *Târîx-e jahân gûshâ-yî*. J.II, 1385, 746.

<sup>4</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi’ âl-tâwârîx*. J.II, 1383, s. 977.

<sup>5</sup> Энэхүү тайлан-илтгэлийг М. Minovi ба V.Minorsky хамтран эрдэм шинжилгээний тайлбар, зүүлтийн хамт нийтлүүлсэн: M.Minovi and V.Minorsky, “Nasir al-Din Tusi on Finance”. *BSOAS*, vol 10, No.3, London 1940, 755-789

<sup>6</sup> M.Minovi and V.Minorsky, “Nasir al-Din Tusi on Finance”. *BSOAS*, vol 10, No.3, London 1940, 756

<sup>7</sup> M.Minovi and V.Minorsky, “Nasir al-Din Tusi on Finance”. *BSOAS*, vol 10, No.3, London 1940, 756

сангийн түшмэд (*hâsl-e daxel va xaḡj-e negâh dârand*) хэмээн ангилсан<sup>1</sup> бөгөөд харин тус бүрд нь дэлгэрүүлэн тайлбарлахдаа төрийн түшмэд болон сангийн түшмэдийн хэрэг болох төрийн орлого, зарлагыг хэрхэн ангилах, бүрэлдүүлэх ба тооцоолох журмыг голлон өгүүлжээ. Хожмын үйл явдлын өрнөлөөс үзэхэд уг тайлан-илтгэл нь Ил хаант улсын эдийн засгийн амьдралыг зохицуулах үндсэн журмын үүрэг гүйцэтгэсэн нь харагддаг. Өөрөөр хэлбэл Хүлэгү хан улсын иргэний удирдлага ба санхүүгийн амьдралыг түүчээлэх гол хүчин нь везирийн тогтолцоо болохын чухлыг үнэлэн 1263 онд болсон их хуралдайгаар Шамс Ад-дин Мухаммед Жувейниг сахиб-и диван цолтойгоор улсын везир болгон томилжээ<sup>2</sup>. Шамс Ад-дин Мухаммед Жувейни нь уг албан тушаалыг Хүлэгү, Абага, Ахмед Тэгүдэр ханы үеийг дамжин 1284 он хүртэл хашихдаа Ил хаант улсын везирийн тогтолцоог Исламын везирийн уламжлалт тогтолцоог Ираны онцлогтой уялдуулсан Их Селжүкийн үеийн Низам ал-Молкийн загвараар хөгжүүлсэн ажээ<sup>3</sup>.

## ***2. Везирийн үүрэг хийгээд бүрэлдэхүүн албад***

Исламын төрийн онолд везирийг эрх үүрэг болон төрийн хэрэгт оролцооных нь байдлаар *vazârat âl-tafvîz* хийгээд *vazârat âl-tanfîz* хэмээн хоёр ангилдаг. *Vazârat âl-tafvîz* ангиллын везир нь төрийн хэргийг өөрийн үзэмж, шийдвэрээр удирдах бөгөөд зөвхөн халиф болон угсаа залгамжлах ханхүүгийн зүгээс томилогдсон албан хаагчид, шашны удирдагчийг халахаас бусад бүхий л хэргийг удирдан зохион байгуулна. Харин *âl-tanfîz* ангиллын везир нь халифын зүгээс өгөгдсөн заавар, тушаалын дагуу төрийн хэргийг удирдах бөгөөд заримдаа төрийн хэргийн хүндээс шалтгаалан цэрэг хийгээд сангийн хэргийг тус тусдаа эрхлэх хоёр везир томилогдох тохиолдол ч байна. *Vazârat âl-tafvîz* везир нь ямар ч үед зөвхөн нэг хүн байдгаараа онцлогтой<sup>4</sup>. Везирийн энэхүү ангилал нь тусгайлан заагдсан зүйл биш бөгөөд тухайн үеийн везирийн нэр хүнд, харизм болон халиф, султануудын онцлогоос хамааран тодорхойлогддог билээ. Өөрөөр хэлбэл, хувийн зан чанар, харизм, арга ухааны ачаар халиф, султанд нөлөөлөн төрийн хэргийг ерөнхийлөн атгаж чадсан эсэхээс хамааран исламын түүхчид уг хоёр ангиллыг оноодог.

<sup>1</sup> M.Minovi and V.Minorsky, "Nasir al-Din Tusi on Finance". *BSOAS*, vol 10, No.3, London 1940, 758

<sup>2</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 977; Fahr âl-Dîn Dâvûd Banâkatî. *Târîx-e Banâkatî*. Tashîh Jafar Sh'îâr, Tehran., 1378, 425.

<sup>3</sup> Ankhbayar Danuu. *Îlhanlı Devleti'nde Vezaret*. Yayınlanmamış Doktora Tezi, Ankara Üniversitesi Sosyal Bilimler Enstitüsü Tarih Bölümü, Ankara., 2016, 143-170.

<sup>4</sup> "Vezir". *İslam Ansiklopedisi*, C.XIII, İstanbul., 1986, 310; Mâvardî, Âbû âl-Hasan 'Alî bin Muhammed bin Habîb âl-Basrî âl-Baghdâdî. *Ketâbül-Ahqâmi's-Sultânîyyeh*, Matbaatü'l Vatan, Misr, 1298, 21; Cor-cî Zeydân, *İslam Uygarlıkları Tarihi*, çev. Nejdî Gök, Cilt I, İletişim Yay, İstanbul, 2004, 204-207.

Ил хаант улсын везир нь Амударьяагаас Мисир, Ормузын эргээс Дербенд хүртэлх Ил хаадын газар нутаг дахь шашныг хүчирхэгжүүлэх, сүсэг бишрэл, шашинд итгэгчдийн үйл хэргийг мандуулах, мужуудын зохион байгуулалт, ажил хэргийг өөртөө итгэлтэйгээр удирдах, өмч хөрөнгө, харьяат иргэдийг тохинуулахтай холбоотой бүхий л үйл хэргийг олгогдсон хувь тавилан, эрх мэдлийнхээ хүрээнд залж чиглүүлэх, ядуу доордын нуруунд хүнд ачаа үүрүүлэхгүй байх, их диван (*dīvân-e bozorg*), сан (*xazâneh*), зэвсэг хэрэгсэл (*lavâzemât-e selâh*), үйлдвэр (*kârxâneh*), агтны хэрэг (*âxtâ*) хүнсний хэрэг (*matbaha*) болон бусад хэсгүүдээс бүрдэх дивануудын эрдэм чадалтай бичээч (*bitîkchî*) болон бичигч (*kuttâb*) нарыг удирдах, тэдэнд зохих ажлуудыг даалгах, бүх данс болон зарлагын бүртгэлүүдэд тооллого хийлгэх, мэдлэг, чадвартай хүмүүсийг сонгон олж бүс нутаг, мужийн захиргаанд томилох, шахне тушаалтнуудын ардаас илүү эд зүйл, татвар үл хураахыг даалгах болон шалгах, хэрэгтэй гэж үзвэл уг ажлыг чадвартай өөр нэгэнд шилжүүлэх<sup>1</sup>, сахиб-и диван нар, бичээч болон диваны бусад гишүүдийн зэрэгцээ мужийн захирагч (*hâkem*), шахне нарыг томилох халах, мужийн сангийн хэргээс улсын зарлага (*âxgâjât-e mamâlek*) болон сангийн бүхий л данс тэргүүтэй санхүүгийн эмх цэгцийн асуудлаар туслагч нартайгаа хамтран бүрэн эрх эдлэх<sup>2</sup> зэрэг үндсэн үүргийг хүлээдэг байв. Үүний зэрэгцээ өртөөний алба, барилгын үйл ажиллагаа, зоос дэлдэх хийгээд өмчийн зохион байгуулалтын ажлуудыг ч ерөнхийд нь удирдан чиглүүлнэ<sup>3</sup>. Везирийн өдөр тутмын үйл ажиллагаа нь санг арвижуулах, диваны хөрөнгийн бүртгэл, улсын чухал хэргүүдийг шийдэх бүрэн эрхтэй бөгөөд Ил ханы хувь, гувчуур, хараж зэрэг татварыг тодорхойлсон санхүүгийн журам боловсруулах, өртөөний зохион байгуулалт, бүтээн байгуулалт сэргээн засварын ажлууд, зоос дэлдүүлэх, сангийн өмчийн зарцуулалтын тухай тушаалыг бичүүлэх хийгээд хувилан олшруулж зүг бүрт илгээх зэргээс бүрддэг байв<sup>4</sup>. Везирийн ажил үүргийн тухай өөр нэгэн тодорхойлолтыг Ибн-и Биби бээр Абага хан везир Шамс Ад-дин Мухаммед Жувейнийг Анатолид томилох үедээ “ардын хүсэлтийг биелүүлэх, улсыг бүтээн байгуулах, улсын захиргааг гартаа оруулах, зальт болон самуун этгээдүүдийн хөрөнгө, санхүүгийн дансыг үйлдэх, хүмүүсийн айдсын шалтгааныг олох, хилийн бүсийг хамгаалах, үймээнийг дарах,

<sup>1</sup> Muhammed bin Hindûshâh Nahjûvânî. *Dastûr âl-kâteb fi t'ayîn âl-marâteb*. Tashîh Abdolkarîm 'Alîôglî '-Alîzâdeh, J.II, Moskva, 1976, 76-77.

<sup>2</sup> Muhammed bin Hindûshâh Nahjûvânî. *Dastûr âl-kâteb fi t'ayîn âl-marâteb*. J.II, 1976, 79-80.

<sup>3</sup> E.D. Philips, *The Mongols*, Publisher Thames and Sudson, London 1969, 118.

<sup>4</sup> Shahâb âl-dîn 'Abdâllâh bin Fazl âllâh Shîrâzî. *Tahrîr-e Târîx-e Vassâf*. Be qalam 'Abd âl-Muhammed Âyîfî. Tehran., 1383, 193.

өддөн хатгагчдыг шийтгэх, улсын дайснуудыг үгүй хийхийг зарлигдсан” хэмээн өгүүлжээ<sup>1</sup>.

Ил хаант улсын везирүүд ихэнхдээ сахиб-и диваны үүрэгт ажлыг ч хавсран гүйцэтгэдэг байв. Сахиб-и диван нь сангийн хэрэг эрхлэгч сайдын шинжтэй бөгөөд төрийн болон сангийн удирдлага, сангийн хөрөнгийн арвижилт, Ил ханы сангийн (хазне-е has) хөтлөлт, төрийн албан хаагчдын эмх цэгц, өртөөний удирдлага, барилгын ажлын зохион байгуулалт, зоос дэлдүүлэх, сангийн хэрэгцээ зэрэг бүхий л ажлыг удирдан гүйцэтгүүлэх, төрийн сангийн дансыг хөтлөх, татварын зөрчил, цэрэг дайчлах үед албыг хэтрүүлэн хураахтай холбоотой гомдлыг судлах зэрэг ажлуудыг гүйцэтгэдэг байв<sup>2</sup>. Үүний тул везир нь сангийн хэргийг давхар хариуцах тохиолдолд сахиб-и диван хэмээн нэрлэгддэг байв<sup>3</sup>. Өөрөөр хэлбэл, везирийн үүрэгт ажил нь дагасан орнуудын захиргаа, сангийн хэрэг, албан хаагчдын томилгоо, халл, хөрөнгийн зарцуулалтын тухайд бүрэн эрх эдлэх бөгөөд чухал хэргүүд дээр Ил хантай зөвлөлдөн шийдвэр гаргадаг бөгөөд бараг л султан ажгуу<sup>4</sup>. Гэхдээ улс төр, гадаад харилцаа, цэргийн хэрэг зэрэг төрийн гол чухал хэргүүд Монгол ноёдын гарт төвлөрч байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Ил хаант улсын везир нь цэрэг, улс төр, гадаад харилцаанаас бусад төрийн хэрэгт оролцон чухал алба хэсгүүдийг даргалдаг байсан тул түүний доор тухайлсан үүрэг хүлээсэн түшмэд, албан хаагчид ажилладаг байв. Везирийн гүйцэтгэж буй ажилд туслах үүрэг бүхий орлогчийн захиргаанд буй хэсгийг везирт туслах алба (nîyâbet-e vazârat) байсан бөгөөд захирагчийг нь nâuyb-e vazârat гэж нэрлэдэг байв. Nâuyb-e vazârat нь их диван болон бусад түшмэдийн дунд хамгийн дээд албан тушаалтан бөгөөд сангийн тооцоог хянан мөнгөн дүн, хэмжээ зэрэг зарцуулалтын хэргийг эрхлэхээс гадна их дивангийн хэлэлцэх асуудлуудыг боловсруулан оруулж ирдэг. Түүний өдөр тутмын ажил нь диван дахь везирийн бүхий л хэргийг эмхтгэн везирт айлтгах ба диваны дэвтэр, гүйцэтгэл (âvârîjat), зарчим (dastûr), хэрэг явдлын бүртгэл (rûznâmcheh), үлдэгдэл (baqîyeh), зарлагыг (masrâf) нэгтгэн везиртэй зөвлөлдөнө. Үүний тул албан бичгүүдэд везирийн хамт гарын үсэг зурах ба шийдэгдээгүй хэргүүдийг везир болон ноёдод танилцуулдаг байв<sup>5</sup>.

<sup>1</sup> İbn Bibi. *El Evamirü'l-Ala'iyе Fi'l-Umuri'l-Ala'iyе (Selçuk name)*. Çev. Mürsel Öztürk, TCKBY, Ankara, 1993, 215.

<sup>2</sup> Bertold Spuler. *İran Moğolları: Siyaset, İdare ve Kültür (İlhanlılar Devri 1220-1350)*. 1987, 321-322.

<sup>3</sup> И.П.Петрушевский. Иран, Азербайжан Хулагугийнхний ноёрхолд (1256-1353). *Монгол-Татаарууд Ази, Европт*. Улаанбаатар: 1984, 274; An Swynford Lambton. *Tedâvüm ve tahavvül dar Târix-e Miyaneh-e İrân*. Terjume Yâkûb Ajand, Tehran., 1386, 66.

<sup>4</sup> Âhmed bin 'Alî âl-Qalqashandî. *Subh âl-Â'shâ fi Sanâ'ayeh âl-Ânshâ'*. Sharh Muhammed Huseyîn Shams âl-Dîn. J.IV Beyrut., 1987, 422.

<sup>5</sup> Muhammed bin Hindûshâh Nahjûvânî. *Dastûr âl-kâteb fi t'ayîin âl-marâteb*. J.II, 1976, 122-123.

Везирийн дэргэд байх онцгой эрхтэй албан тушаалтан бол *âshraf-e mamâlek* бөгөөд сурвалжид *dîvân-e âshraf* болон *moshraf* зэргээр тэмдэглэгддэг<sup>1</sup>. Түүний үндсэн үүрэг нь сахиб-и диванатыг хянан шалгах явдал байв<sup>2</sup>. Тэрээр сангийн болон захиргааны бүхий л диван болон улсын бусад албадыг хянан шалгах үүрэгтэй өндөр мэдлэгтэй нэгэн байна. *Âshraf-e mamâlek* нь хэн нэгэнд хандан ажил үүрэгтэй нь холбоотой асуулт тавьсан нөхцөлд тэр даруйд нь хариулан нөхцөл байдлыг тайлбарлах үүрэгтэй<sup>3</sup>. Сан, төрийн төсөв, зардал, цэргийн цалин, хэрэг зарга, хүнс зэрэг чухал хэргүүдийг нарийн хянах бөгөөд их диваны захиргаа, санхүүг байнгын хяналтандаа барих бөлгөө. Ийнхүү албан үүргээ гүйцэтгэхдээ улсын амираас (*âmîr-e ûlûs*) аравтын дарга хүртэлх цэргийн эрхтэн, везират, сахиб-и диванатын бүх албан хаагчдыг хянах бөгөөд мэдээллийг цаг тухай бүрт нь авна. Тийм ч учраас диваны бүх дэвтэр (*jamî'a defâtîr*), зарчмууд (*desâtîr*), албан захидлуудад (*maktubât*) түүний гарын үсэг, тэмдэг дарагдана. Төрийн түшмэдийн томилгоо болон доод албан тушаалтнуудаас диванд илгээсэн хэрэг айлтгалуудад *âshraf-e mamâlek*-ийн санал зөвшөөрлийг заавал авдаг байв. Учир нь тэрээр бүх мужуудад илгээсэн орлогч болон *moshraf*-уудаараа дамжуулан бүхий л хэргийг мэддэг байлаа. Тэдгээр орлогчдыг нь хотын байцаагч (*âshraf-e shahr*) мужийн байцаагч (*âshraf-e valâyît*) гэх бөгөөд хариуцсан газрынхаа санхүү болон эдийн засгийн байдлыг хянан үр дүнг нь дээд тушаалтандаа илгээх үүрэгтэй байв<sup>4</sup>. Ийм ч учраас түүнийг албан тушаалд нь Ил хан томилж чөлөөлдөг байв<sup>5</sup>.

Везирын бүрэлдэхүүнд багтан санхүүгийн хэргийг голчлон эрхлэх албан тушаал нь *mostavfi-ye mamâlek* байв. Уг албан тушаал нь эхний үед *Daftardârî mamâlek* буюу санхүүгийн хэрэг эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгч хэлбэрээр тогтнож байжээ. Энэ албанд ажиллагч түшмэдүүдийн албан тушаалыг *Mostavfi* хэмээн нэрлэнэ. *Daftardârî mamâlek* –ийн албан тушаалд буй түшмэл нь Ил хаант улсын татвар хураалт, тооцооны дэвтрүүдийг хөглөхийн зэрэгцээ татварын хөнгөлөлт болон өршөөл хүсэгчдийн хэргийг судлана. Дэргэдээ буй түшмэлүүдээс хөрөнгө болон эдийн засгийн бусад асуудлаар гарсан гомдлуудыг судлан шийдвэрлэнэ. Дээрх төрлийн гомдол орон нутаг болон мужуудаас ирсэн тохиолдолд тэндхийн дэвтрүүдэд хэрхэн бичигдсэн байдлаар нь авч үзсэний дараа хэрхэн шийдвэр гаргах тухай санал, зөвлөмжийг боловсруулан везир болон сахиб-и диванд

<sup>1</sup> Shamîs Sharîk Âmîn. *Farhang-e Estlâhât-e Dîvânî-ye Dôvrân-e Moghól*. Tehran., 1357, 220.

<sup>2</sup> Bertold Spuler. *Iran Moğolları: Siyaset, İdare ve Kültür (İlhanlılar Devri 1220-1350)*. 1987, 322.

<sup>3</sup> Muhammed bin Hindûshâh Nahjûvânî. *Dastûr âl-kâteb fi t'ayîin âl-marâteb*. J.II, 1976, 112

<sup>4</sup> Muhammed bin Hindûshâh Nahjûvânî. *Dastûr âl-kâteb fi t'ayîin âl-marâteb*. J.II, 1976, 113-114

<sup>5</sup> Rashid âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1114

айлтгана<sup>1</sup>. Газаны үеэс эхлэн Daftar-e Dîvân-e mamâlek-ийн дэргэд бичиг хэрэг, архивын шинжтэй албыг (daftarxâneh) байгуулсан бөгөөд тэнд цаас, бийр, бэх, дэвтэр, хор болон өдөр тутмын хэрэг хөтлөлтийн дэвтэрт зориулсан ширэн хавтас зэрэг хэрэгслүүдийг хадгалдаг болов. Ил ханы ордон нүүх үест daftarxâneh-ийн эдлэл хэрэгслүүдийг хайрцаганд хийж тэмээнд ачна. Уг албаны салбарууд Багдад, Исфахан, Тебриз, Нахчиван болон Ираны бусад мужуудад байгуулагдав<sup>2</sup>. Mostavfi нар санхүү худалдааны хэрэг хөтлөх бичгийг (sîyâq) сайтар эзэмшсэн байх ёстой бөгөөд дивандаа бүх хэргийн дэвтэр (daftar-e Jâm'ia) гаргасан шийдвэрүүдийн дэвтэр (daftar-e mukarrâr), ажлын гүйцэтгэлийн дэвтэр (daftar-e âvârîjeh), хараж татварын дэвтэр (daftar-e xâraj), хууль тогтоолын дэвтэр (daftar-e qânûn), хэлэцүүлгийн дэвтэр (daftar-e tavajehat), өдөр тутмын хэргийн дэвтэр (daftar-e rûznâmcheh) хэмээх 7 ширхэг дэвтэр хөтлөнө<sup>3</sup>. Mostavfi-ye mamâlek нь хэдийгээр зөвхөн санхүүгийн хэргийг эрхлэх боловч үүргийн дагуу засаг захиргаа, улс төрийн бодлогод ч оролцдог байв. Учир нь ноёд, цэргийн хэрэглээний санхүүг гаргадаг учир икта болон янаг (înâq) сонгох зэрэг ажлуудад өөрийн санал бодлоо илэрхийлэх зэргээр оролцоно. Уулаасаа санхүүгийн үйл ажиллагаа, сан бүрдүүлэх зэрэг албан үүргийн улмаас цэргийн зэвсэглэл, цэрэг хөдөлгөх, зэвсэг нөөцлөх зэрэг ажлуудад санал дүгнэлт хэлэхээс гадна ихэнх тохиолдолд зөвшөөрөл өгөх албан тушаалтан нь Mostavfi-ye mamâlek байлаа. Уг албаны жилийн төсөв нь 20 мянган алтан динар бөгөөд дутсан тохиолдолд онцгой мужуудын (valâyit-e has) орлогоос нөхнө<sup>4</sup>.

Өгэдэй хааны үед Хорасаны диванатад бий болсон Их бичээч (ûlûgh bitîqchî) хэмээх албан тушаал нь Ил хаант улсын везирийн тогтолцоонд ûlûgh bitîqchî-ye mamâlek нэрээр уламжлагджээ. Их бичээч нь Их диваны ахлах бичээч бөгөөд диванаас гарсан бүх зарлиг, тогтоолын бичгүүдийг бичүүлэхээс гадна диваны санхүүгийн хэргийг хөтлөх ба диваны төсвийг нэмэгдүүлэх талаар холбогдох албан тушаалтнуудтай тохироо хийнэ. бүх хэргийн дэвтэр (daftar-e Jâm'ia) болон зарлагын дэвтрийг хөтлөхөөс гадна диваны бичиг хэргийн бүх ажлыг толгойлно. Бүх бичгийг ойлгомжтой хялбар болгох үүднээс ард талд нь товчлол үйлдэх бөгөөд бүх мужуудад өөрийн орлогч, бичээч нарын томилгоог хариуцна<sup>5</sup>. Ил

<sup>1</sup> Muhammed bin Hindûshâh Nahjûvânî. *Dastûr âl-kâteb fi t'ayîin âl-marâteb*. J.II, 1976, 125-126

<sup>2</sup> Muhammed bin Hindûshâh Nahjûvânî. *Dastûr âl-kâteb fi t'ayîin âl-marâteb*. J.II, 1976, 130

<sup>3</sup> 'Abd âllâh bin Muhammed bin Qîyâ Al-Mâzandarânî, *Resâleh-e Falakîyyah*, Tashih Walter Hinz, chaphane-e Frans Ştayner, Wiesbaden, 1952, 80-81

<sup>4</sup> Muhammed bin Hindûshâh Nahjûvânî. *Dastûr âl-kâteb fi t'ayîin âl-marâteb*. J.II, 1976, 98-99

<sup>5</sup> Muhammed bin Hindûshâh Nahjûvânî. *Dastûr âl-kâteb fi t'ayîin âl-marâteb*. J.II, 1976, 107-108

ханы зарлигийн бичгийг Их бичээчийн доорх Монгол бичээч нар машид нарийн хянасны дараа Ил ханд өргөнө. Ийнхүү ал тамга дарагдсан бүхий л зарлигийг дэвтэрт хуулбарлан бичиж үлдэх бөгөөд уг зарлигийг хэзээ, хэн бичсэн тухай тэмдэглэл үйлдэнэ. Түүгээр ч үл барам Газан ханы үе хүртэл Ил ханы тамганы хайрцгийн түлхүүр бичээч нарын гарт байлаа<sup>1</sup>.

Ил хаант улсын везирийн тогтолцоонд нэр нь гарах Улсын сайд (*Nâzîr-e mamâlek*) гэгдэх албан тушаалтан нь их диваны өдөр тутмын ажил хийгээд сангийн хэргийг эрхэлдэг байв. Их ноёд, түмний ноёд, янаг болон диваны бичээч нарын зэрэг албан тушаалтнуудын цалингийн хэргийг эрхлэх бөгөөд цол олгох, албан тушаал дэвшүүлэх тодорхойлолтуудыг үйлдэнэ. Диваны бүх бичиг данс, тогтоол, тодорхойлолт, шүүхийн бичиг, сар бүрийн хүн ам, өдөр тутмын хэргийн дансанд гарын үсэг, тэмдэг дарах ба бүх мужуудад өөрийн орлогчдыг томилон явуулах эрхтэй<sup>2</sup>. Харин уг албыг хашигч түшмэлийн тухай сурвалжийн мэдээ хомс бөгөөд зарим талаараа *âshraf-e mamâlek* болон *ûlûgh bitîqchî*-тэй төстэй байдгаас үзвэл уг хоёр тушаалтны доорх түшмэл хэмээн үзвэл зохистой<sup>3</sup>.

Их диваны нарийн бичиг (*Monshî-ye dívânî bozorg*) хэмээн нэрлэгдэх албан тушаалтан нь Ил хан, их ноёд, везир тэргүүтэй өндөр албан тушаалтнуудад бичих захидал, зарлиг, тогтоол, майлтгал мэдээлэл зэргийг бичих бөгөөд хүн тус бүрийн цол, хэргэм, албан тушаалд тааруулсан найруулгыг бэлддэг байв. Эдгээр бичгүүд нь гайхалтай эмх цэгцтэй бөгөөд ямар нэгэн далд утга санаагүй байдлаар найруулагдах ёстой. Их диваны нарийн бичгийн өөр нэгэн онцлог бол тэрээр Ил ханы нууцыг хадгалагч байх явдал юм. Тийм ч учир түүний ажилд хэн ч хөндлөнгөөс оролцохгүй бөгөөд түүний доор *kuttâb* хэмээх эх бэлтгэгчдийн хэсэг байна. Тэд нар их диваны албан хаагчийн цалингаас гадна зохиосон эх бүртгээ илүү цалин бодуулдаг<sup>4</sup>.

Везирийн дэргэд байх төвийн албан хаагчдаас гадна муж бүрт түүний орлогч болох захирагч (*hâkem*) хэмээх тушаалтнууд орон нутгийн иргэний захиргааг удирддаг байв. эдгээр албан тушаалтнууд нь хэдийгээр везирийг төлөөлж буй боловч Ил ханы зүгээс томилогдоно. Захирагч нар тухайн мужийн санхүү тэргүүтэй иргэний захиргааны хэргийг явуулах бөгөөд ажлаа их диванд тайлагнана. Захирагчийн томилолтын хугацаа 3 жил бөгөөд түүний тамгын газарт

<sup>1</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1467-1468

<sup>2</sup> Muhammed bin Hindûshâh Nahjûvânî. *Dastûr âl-kâteb fi t'ayîin âl-marâteb*. J.II, 1976, 10

<sup>3</sup> Ân Swynford Lambton. *Tedâvûm ve tahavvûl dar Târîx-e Mîyâneh-e Îrân*. 1386, 70-71

<sup>4</sup> Muhammed bin Hindûshâh Nahjûvânî. *Dastûr âl-kâteb fi t'ayîin âl-marâteb*. J.II, 1976, 120-121

диваны албан хаагчид, татварын байцаагч (*motasarrîf va tamghâchî*) нарын түшмэд ажиллана<sup>1</sup>.

Ил хаант улсын везир нь улс орны амьдралыг зохицуулж, залан чиглүүлэх үүрэг бүхий Дээд диваны (*Dîvânî 'Alâ*) орлогчийн үүргийг гүйцэтгэнэ<sup>2</sup>. Үүнээс гадна бүх диваны толгойлогч нараас бүрдсэн нийт диваны хэргийг эрхлэх их диваныг толгойлно. Улсын хэмжээн дахь бүх диванууд гаргасан шийдвэр болон саналаа сахиб-и диванаар дамжуулан везирт илгээх бөгөөд тэрээр их диваны гишүүдтэй зөвлөн эцсийн шийдвэрийг гаргах ажгуу<sup>3</sup>.

Везирийн тогтолцоон дотор *Mostavfi-ye mamâlek*-ийн толгойлсон сангийн диван (*Dîvân-e Estîfâ*), Их диваны нарийн бичгийн толгойлсон бичгийн диван (*Dîvân-e Enshâ'a*), шашин болон буяны ажил хариуцсан жасын диван (*Dîvân-e Âvqâf*), Ил хан болон түүний гэр бүлийн эзэмшил газрын хэргийг эрхлэх диван (*Dîvân-e Injû*), атар газрыг эзэмших хэргийн диван (*Dîvân-e Hâlesat*), зоос дэлдэх болсон сорьцын диван (*Dîvân-e Dâr âl-Zarb*), жингийн зам, мадраса, шашны сургууль, сүм, халуун усны газар, карвансарай, бясалгалын газар, өртөө зэрэг олон нийтийн үйлчилгээний диван (*Dîvân-e Âmârat*), нийтийн эзэмшлийн газрын диван (*Dîvân-e Dalâuyî*) зэрэг олон төрлийн диванууд нийгмийн бүхий л салбарыг албан үүргийн дагуу хуваарилан хариуцдаг байв<sup>4</sup>. Везир болон сахиб-и диван нь улс орны санхүү, эдийн засгийн амьдралыг голлон эрхэлдэг тул улсын сангийн хэргийг эрхэлсэн газрыг (*zabet-e kâr-e hazâneh*) мөн хариуцна. Улсын сан нь дотроо үнэт зүйлсийг нөөцөлж хураах зорилго бүхий нарийн сан (*nârîn*) хийгээд өдөр тутмын зардлыг гаргах зорилготой бүдүүн сан (*bîdûn*) хэмээн хоёр хуваагдана. Уг сангуудын удирдлагыг хариуцсан түшмэл явуулах бөгөөд ордны санхүүчид (*xwâjeh-e sarâyî*) хяналт тавьна. Сангийн зарлага болон сангаас эд зүйлс гаргах ажил нь эхлээд везирийн зөвшөөрөл авсны дараа Ил ханы цохолтоор гүйцэтгэгдэнэ. Сангийн эд зүйлсийг шамшигдуулахаас сэргийлж 6 сар тутамд везирийн зүгээс шалгалт оруулдаг байв<sup>5</sup>.

Ийнхүү везирийн тогтолцоо нь харъяа диван болон бусад албадад алба хашиж буй түшмэдийг багтаасан улс орны иргэний захиргааг удирдах дээд байгууллага байв. Султание хотод баригдсан дивануудын ордны (*Dîvânkhâneh*) багтаамж

<sup>1</sup> Muhammed bin Hindûshâh Nahjûvânî. *Dastûr âl-kâteb fi t'ayûin âl-marâteb*. J.II, 1976, 136-137

<sup>2</sup> Âhmed Furûgh Bahîş. Se Dîvân-e Mohim dar 'Ahd-e Îlxânî, *KMTC*, Shomare 81-83,1383, Tahran: 81

<sup>3</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Mukâtabât-e Rashîdî*. Tashih Muhammed Shefih, Lahor, 1945, 19

<sup>4</sup> Ankhbayar Danuu. *Ilhanlı Devleti'nde Vezaret*. Yayınlanmamış Doktora Tezi, Ankara Üniversitesi Sosyal Bilimler Enstitüsü Tarih Bölümü, Ankara., 2016, 315-317

<sup>5</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1509-1511

2000 хүнтэй байдгаас<sup>1</sup> улбаалан везирийн тогтолцоон дахь албан хаагчдын тоог төсөөлөх боломжтой. Гэхдээ энэ нь зөвхөн нийслэл хотод байгаа диваны албан хаагчдын тоо бөгөөд бүх мужуудад салбар диванууд байдгыг ч мөн бодолцох хэрэгтэй. Эдгээр албан хаагчдын дийлэнх олонх нь тухайн орон нутгийн гаралтай хүмүүс гэж тооцвол Ил хаант улсын төрийн удирдлага дахь Иран гаралтай үзэгт хүмүүсийн нөлөөг ч ойлгох боломжтой юм.

### **3. Монгол ноёд хийгээд везирийн тогтолцоо хоорондын харилцаа, зөрчил**

Везирийн тогтолцоо нь Ил хаант улсын иргэний захиргааг төвлөрүүлэн барьснаар улс орны эдийн засгийн амьдралыг зохицуулах болон хөтлөх үүргийг гүйцэтгэж байв. Харин Монгол ноёдын бүлэг төр-цэргийн удирдлагыг барьж байв. Өөрөөр хэлбэл, төрийг үндэслэн байгуулагч Монголчууд цэргийн аристократ буюу сэлэмт хэсгийг төлөөлж байгаа бол жингийн нөгөө талд орон нутгийн гаралтай Иран түшмэд нь засаг захиргаа, сангийн хэргийг барин үзэгтэн буюу бюрократ хэсгийг төлөөлдөг байв. Ийнхүү төрийн удирдлага нь хоёр үндсэн хэсгээс бүрэлдэх бөгөөд Ил хан тэдний хооронд тэнцвэрийг зохицуулагч шүүгчийн үүрэг гүйцэтгэж байлаа. Энэхүү хоёр хэсгийн хооронд өрсөлдөөн болон зөрчил хэмээн тодорхойлж болохуйц харилцаа бүр 1230-аад оны Хорасан диванатын үеэс эхэлсэн байдаг. Мэдэгдэж байгаачлан Хорасаны анхны захирагч Чинтөмөр болон Тайр баатрын хоорондох маргаан<sup>2</sup>, Күркүз болон Цагадайн ноёдын хоорондын заргаар<sup>3</sup> илэрсэн зөрчил нь Хорасаны иргэний захиргааг Монгол ноёдын мэдэлд өгөх хүртэл үргэлжилжээ. Хорасаны иргэний захиргаа болох Хорасаны диванат болон тус бүс дахь Монгол цэргийн жанждын хооронд буй болсон зөрчлийн гол шалтгаан нь Иран дахь Монгол цэргийн хангамжийг хэрхэн гаргах асуудал байв. Хорасаны диванатын захирагч Чинтөмөр нь цэргийн жанждын дайчлан гаргуулж буй татварт хязгаарлалт тогтоох болон Хорасанд иргэний захиргааг тэргүүлэх байр суурьтай болгохын тулд Өгэдэй хаанд хандан бага ч гэсэн амжилт олж байв<sup>4</sup>. Чинтөмөрийг залгамжилсан Күркүзийн үед Хорасаны диванатын эрх мэдлийн хүрээ Азербайжан хүртэл тэлж татварын бодлогод өөрчлөлт гарсан нь Монгол ноёдын эрс эсэргүүцэлтэй тулгарч улмаар Күркүзийн цаазлагдах

<sup>1</sup> Muhammed bin Xāvandshāh Mīrxōnd, *Tārīx-e Ravzat āl-sefā*. Tashih Jamshid Qiyānfar, J.V, Tehran: 1385, 4263-4264; Ghīyās āl-dīn Humām āl-dīn Xavāndamīr, *Āsār āl-mulūk*. Tashih Mir Hashim Mu-haddis, Tehran., 1372, 160

<sup>2</sup> ‘Alā’ āl-Dīn ‘Atā Malek Jūwāinī. *Tārīx-e jahān gūshā-yī*. J.II, 1385, 708

<sup>3</sup> ‘Alā’ āl-Dīn ‘Atā Malek Jūwāinī. *Tārīx-e jahān gūshā-yī*. J.II, 1385, 726-727

<sup>4</sup> ‘Alā’ āl-Dīn ‘Atā Malek Jūwāinī. *Tārīx-e jahān gūshā-yī*. J.II, 1385, 708

шалтгаан болжээ<sup>1</sup>. Улс төрийн ухаан, харизмаар бусад ноёдоос ялгарсан Аргун ахыг Хорасан диванатад томилсонд тэрээр Иран түшмэдтэй гар нийлэн ажиллаж эхэлсэн байдаг<sup>2</sup>. Гэвч Их хаантай ойр дотно харилцаатай, харизмын хувьд бүгдэд хүлээн зөвшөөрөгдсөн Аргун ахын эсрэг Элжигдэй тэргүүтэй цэргийн ноёд хуйвалдаан зохиосон боловч амжилт олоогүй билээ<sup>3</sup>. Хорасан диванатын үед буй болсон энэхүү зөрчилт байдал нь Ил хаант улс байгуулагдсан хойно ч везир-ноёдын хооронд мөн л адил үргэлжилсэн билээ.

Ил хаант улсын үед Аргун ах, Байжу, Хэтбуха ноёдоор эхэлсэн улс төр, цэргийн нөлөө бүхий л үед үргэлжилсээр иржээ. Абага ханы үед Сунчиг, Долоодой, Лакзи, Алтажу, Самагар ноёд, Өлзийт ханы үед Амир Кутлукшах, Чобан ноён нарыг цэргийн дээд удирдлагад байсан билээ. Эдгээр ноёд Ил хаадад нөлөө, эрх сүрийн маш давуу байдалтай байсан тул үе үеийн Ил хаад ч тэднийг талдаа барих бодлогыг идэвхтэй явуулж байв. тухайлбал, Ил хан Ахмед Тэгүдэр болон ханхүү Аргун нарын хоорондох мөргөлдөөний үед хүчирхэг ноён Алинакыг талдаа татахын тулд Ахмед Тэгүдэр хан өөрийн гүнжээ өгч ураг барилдаж байв<sup>4</sup>. 1291 онд амир Чобан болон Курмиши нар Гайхату ханыг дэмжиж ширээнд суулгасан боловч бусад ноёд үл зөвшөөрөн эсэргүүцэж бослого эхлүүлсэн тохиолдол ч бий<sup>5</sup>. Тэр ч байтугай зарим ноёд хүчирхэг Монгол ноёд Ил хантай ширээ булаалдах төвшинд ч ирж байлаа. Газан ханы үед Навруз, Абу С'айд ханы үед Чобан нар сүр хүч, эрх мэдлээрээ Ил хаадыг бараг даван гарч төрийн эрхийг атгалцаж байв. Монгол ноёдын бүлгийн толгойд бэглэрбэй хэмээх цолтой нэгэн байх бөгөөд түүний доор улус амир хэмээх 3 ноён, дараа нь цолны шатлалаар үлки амир, түмт, мянгат, зуут, аравтын ноёны шатлалтай байв. Араб, Перс сурвалжуудад умера хэмээн нэрлэгдэх энэхүү давхрааны гарт цэргийн бүх удирдлага оршиж байжээ<sup>6</sup>.

Монгол ноёдын бүлэг ийнхүү улс төр, цэргийн эрх мэдлээс гадна эдийн засгийн томоохон хүчин чадлыг ч захирч байв. Монгол ноёдын мэдэлд инжү хэмээн нэрлэгдэх газар эзэмшил байсан бөгөөд энэ нь Ил хан болон түүний хатад, хан хөвүүд, алтан ургийн ноёдод олгогдсон газар юм<sup>7</sup>. Инжүгийн хэмжээ

<sup>1</sup> 'Alā' āl-Dīn 'Atā Malek Jūwaīnī. *Tārīx-e jahān gūshā-yī*. J.II, 1385, 715

<sup>2</sup> 'Alā' āl-Dīn 'Atā Malek Jūwaīnī. *Tārīx-e jahān gūshā-yī*. J.II, 1385, 729

<sup>3</sup> 'Alā' āl-Dīn 'Atā Malek Jūwaīnī. *Tārīx-e jahān gūshā-yī*. J.II, 1385, 744

<sup>4</sup> Rashīd āl-Dīn Fazl Āllāh Hamadānī. *Jāmi' āl-tāwārīx*. J.II, 1383, 1134

<sup>5</sup> Rashīd āl-Dīn Fazl Āllāh Hamadānī. *Jāmi' āl-tāwārīx*. J.II, 1383, 1190

<sup>6</sup> Ankhbayar Danuu. *İlhanlı Devleti'nde Vezaret*. Yayınlanmamış Doktora Tezi, Ankara Üniversitesi Sosyal Bilimler Enstitüsü Tarih Bölümü, Ankara., 2016, 335

<sup>7</sup> И.П.Петрушевский. Иран, Азербайжан Хулагугийнхний ноёрхолд (1256-1353). *Монгол-Татаарууд Ази, Европт*. Улаанбаатар: 1984, 277

Ил хант улсын нийт газрын 1/3 хүртэл хувийг эзэлж байв<sup>1</sup>. Инжүгийн захиргаа зөвхөн Монгол ноёдын гарт байсан бөгөөд Абага ханы үед гэхэд Алтажу ах ноён инжүгийн хэргийг мэдэж байв<sup>2</sup>. Үүнээс гадна икта системийн удирдлага ч Монгол ноёдын харьяанд байсан ба тухайлбал Хүлэгү ханы үед иктагийн хэргийг Аргун ах мэдэж байсан бол Абага ханы үед Сунчиг ноён залгамжилжээ<sup>3</sup>.

Ийнхүү Монгол ноёд өөрсдийн эрх мэдэл, хүч нөлөөгөө амжилттай хамгаалж чадаж байсан тул байр суурийн хувьд везирээс илүү байв. Зарлиг, тушаалын бичгүүдэд эхлээд Ил ханы нэр, дараа нь улсын гурван эмирийн араас везир буюу сахиб-и диваны нэр бичигддэг байв. Гайхату ханы 1293 онд гаргасан нэгэн зарлигийн бичиг “*Ринчиндорж ханы зарлиг, Шигтүр, Акбуха, Тогачарын үг, Ахмед сахиб-и диваны үг*” хэмээн эхлэх<sup>4</sup> бөгөөд энэхүү уламжлал Ил хаадын түүхийн турш мөрдөгдөж байжээ<sup>5</sup>. Үүнээс гадна Ил хаадын ордны дэг журамд везирүүд аливаа хэргийг Ил ханд толилуулах бол заавал Монгол ноёдтой зөвшилцөх ёстой байв. Өлзийт хан үед везир Таж Ад-дин Алишах Гилани бээр нэг удаа шөнө дөлөөр ханд бараалхсан сургийг сонссон Чобан ноён, Ринчин ноён нар хилэгнэн “*Ай халаг! Хүлэгү, Абага ханы үеийн байдал ч өнгөрч дээ. Хэн нэгэн эзэн ханд хэрэг мэдүүлбэл заавал монгол ноёдын зөвшөөрлийг авдагсан. Гэтэл одоо нэг перс хүн монгол ноёдын зөвшөөрөл авалгүй хар шөнөөр ханд бараалхан хэрэг зөвлөж монгол ноёдын үнэ цэнийг үгүй хийж байна. Везир, монгол ноёдыг давахаар барахгүй үг хэлийг нь хүртэл хааж боож байна*” хэмээн агсарснаас<sup>6</sup> энэ журам тодорхой харагдана. Хүлэгү, Абага ханы үед гадаад улс орноос элч ирэх үед ноёд Ил хантай зөвшилцсөний дараа элчид өгөх хариуг тодорхойлдог байлаа. Везирүүд энэ журмыг таашаахгүй байсан тул элч ирэх бүрд ноёд, везирийн хооронд маргаан өрнөдөг байв<sup>7</sup>.

Монгол ноёд болон везирийн хооронд улсын төсвөөс гаргах зарлага болон ялангуяа цэргийн зардлыг хэрхэн хангах тухайд байнгын санал зөрөлдөөн, зөрчил гардаг байв. Иймийн учир Монгол ноёд уг зардлыг хангалттай гаргуулахын тулд заримдаа тусгай аргуудыг хэрэглэдэг байв. Тухайлбал, морь, зэвсэг болон цэргийн бусад хэрэгсэл нийлүүлэх ажилд ордны хорчи, агтач болон бичээч нар тэргүүтэй

<sup>1</sup> Togan, Zeki Velidi. *Umumi Türk Tarihine Giriş*. İstanbul: 1981, 287

<sup>2</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1062

<sup>3</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1062

<sup>4</sup> Âbol'alâ Soudavar, Farman of The Îl-Khan Gaykhatu, *Art of The Persian Courts*, New York: 1992, 34

<sup>5</sup> Özgüdenli, Osman G. İlhanlı Hükümdarı Ebu Sa'id Han'a Ait Dört Yarliḡ. *Belleten*, C. LXIX, sayı 254, Nisan: 2005, 74-76

<sup>6</sup> Abolqasim Abdollah bin Mohammad al-Qashani. *Târîx-e Ôljâitü*. Ehtamam Mohin Hambeli. Tehran: 1384, 195

<sup>7</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1342

Монгол язгууртнууд зуучлах үүрэг гүйцэтгэх явцдаа тогтоосон хэмжээнээс илүү авах болон зөвхөн цаасан дээрх худалдан авалтуудыг хийж байлаа. Ортаг хэмээн нэрлэгдэх худалдаачид ордны хорчи, агтач нарт хахууль өгөх замаар санд морь, зэвсэг болон бусад хэрэгсэл нийлүүлсэн тухай гарын үсэгтэй бичиг үйлдүүлсний дараа диванаас төлөх баталгаа гаргуулан уг мөнгийг мужуудаас дайчлан гаргуулдаг байв<sup>1</sup>. Үүнээс гадна Монгол ноёд язгууртнууд Уйгур худалдаачидтай хамтран зуучлагч нарт хүүтэй мөнгө зээлүүлэх замаар санд эд мал нийлүүлэх ажилд далд байдлаар ч оролцох явдал байлаа<sup>2</sup>. Энэ нь өнгөц харахад хээл хахуулийн хэрэг мэт боловч уг чанартаа цэрэг болон иргэний захиргаа хоорондын харилцааны өвөрмөц шинжийг харуулж буй хэрэг юм. Шамс Ад-Дин Жувейни, Буха, Са'ад Ад-Довла зэрэг хүчирхэг везирүүд төрийн систем дахь энэхүү зөрчилт байдлыг санхүүгийн төвлөрсөн бодлого, орон нутгийн удирдлагыг хүчирхэгжүүлэх зэргээр шийдвэрлэх оролдлогыг хэрэгжүүлсэн боловч тухай бүрдээ санхүү болон иргэний захиргааны дээрх Монгол ноёдын эрхшээл, давуу байдлыг эвдэж чадаагүй билээ.

Ил хаант улсын везир Шамс Ад-Дин Жувейни бээр Хүлэгү, Абага ханы үеийг дамжин дээр өгүүлсэн тэнцвэрийн дагуу уг албан тушаалыг хашиж байв. Энэ үед везирийн тогтолцоо хүчирхэгжих тусам Монгол ноёдын эсэргүүцэл мэдэгдэхүйц хэмжээнд ихсэж байсан ч хямралын хэмжээнд хүрээгүй юм. Харин 1282 онд Абага хан гэнэт таалал төгссөн ба 1282 оны 6-р сарын 21-нд түүний орыг Тэгүдэр залгамжилсан нь<sup>3</sup> Ил хаант улсын түүхийн томоохон эргэлтийг авчирсан үйл явц болов. Тэгүдэр хан лалын шашинд орж Ахмед хэмээх сахилын нэр авсаны дараа нэр хүндээ өсгөхийн тулд үлэмж хэмжээний хишиг тараах, үр ашиггүй зарцуулалт хийх нь ихсэв<sup>4</sup>. Юуны түрүүнд Монгол ноёд болон цэргийнхний талархлыг хүлээхийн тулд цэрэг бүрт 120 динарын өглөг тараасан нь<sup>5</sup> төрийн санд ихээхэн ачаалал үүсгэсэн тул Урмияа нуурын эрэгт орших Тилле болон Шаха цайзад буй эрдэнэсийн санг хоослоход хүргэжээ<sup>6</sup>. Төрийн сан хоосорч эдийн засаг хүндэрсэн энэ үед төрийн везирээр Шамс Ад-Дин Жувейниг улираан томилсон<sup>7</sup> нь түүний

<sup>1</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1490

<sup>2</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1495

<sup>3</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1495; Shahâb âl-dîn 'Abdâllâh bin Fazl âllâh Shîrâzî. *Tahrîr-e Târîx-e Vassâf*. Be qalam 'Abd âl-Muhammed Âyîfî. Tehran: 1364, 66

<sup>4</sup> Тэгүдэрийн хишиг тараалтын тухайд Бар Хебраес ихэд харамсангуй байдлаар дүрсэлсэн байдаг. Abu'l-Farac, Gregory. *Abu'l-Farac Tarihi*. Çeviren Ömer Riza Doğrul, C. II, TTKY, Ankara: 2000, 610

<sup>5</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1127

<sup>6</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1349

<sup>7</sup> Fahr âl-Dîn Dâvûd Banâkatî. *Târîx-e Banâkatî*. Tashîh Jafar Sh'îâr, Tehran: 1378, 438; Ghîyâs âl-dîn Humâm âl-dîn Xavândamîr, *Târîx-e Habîb âl-siyar*. Tashîh Muhammed Dabîr Siyâqî, J. III, Tehran., 1380, 111

санхүүгийн мэдлэгээс гадна лалын гүн сүсэгт нь мөн давхар найдсан хэрэг байлаа<sup>1</sup>.

Ахмед Тэгүдэр хан нь төрийн хэлбэрийг лалын төрт ёсны уламжлалын дагуу шинээр зохион байгуулах шийдвэр гаргасны дагуу везир Шамс Ад-Дин Жувейни тэргүүтэй Иран түшмэд уг ажлыг оройлон гүйцэтгэж эхлэв. Юуны түрүүнд төрт ёсон дахь зарим монгол нэр томъёог араб хэлээрх лалын нэр томъёогоор сольж эхлэв. “Yârîq” буюу зарлиг хэмээх монгол үгийг “farmân” хэмээх ижил утгатай арба үгээр “îlchî” буюу элч хэмээх үгийг “rasûl” зэргээр солихоос гадна Тэгүдэр хан архины оронд айраг буюу “qîmîz” уухыг илүүд үзэх болов. Энэ нөхцөлд шашны удирдагчийг тодорхойлох шаардлага ч урган гарч ирснээр везир Шамс Ад-дин Жувейнигийн дотны анд болох Шейх Камал Ад-Дин Абдуррахман Ар-Рафия-д Шейх Ал-Ислам (Исламын удирлагч) цол олгон Âvqâf-e mamâlek-ийн буюу жасын ерөнхий захирагчийн тушаалд томилов. Шашны үйл ажиллагаанд зориулан хэрэгцээт төсвийг диванаас гаргуулан зарцуулах дүрэм журмыг тогтоох эрхийг Âvqâf-e mamâlek-ийн ажилтнуудад олгожээ. Мусульман бүлэглэлүүдийн бүртгэлийг гарган жил бүр хаж хийх иргэдийн цувааг Багдад төвлөрүүлсний дараа везирийн дүү болох Багдадын захирагч, нэрт түүхч ‘Ата Малек Жувейнигийн зохион байгуулалтын доор Каба буюу Мекка руу илгээх ажлыг албан ёсоор баталгаажуулав<sup>2</sup>. Түүгээр ч үл барам буддын сүм хийдийг лалын сүм-масжид болгон өөрчлөх ажлыг ч эхлүүлэв<sup>3</sup>. Везир Шамс Ад-дин Жувейни улсын эдийн засгийг хөгжүүлэх гол салбар нь гадаад худалдаа болохыг болохын чухлыг айлтгасны дараа Мамлюкын улстай найрамдалт харилцаа үүсгэх саналыг тавив. Энэ үед Шейх Камал Ад-Дин Абдуррахман Ар-Рафия ч мөн Мамлюкын улстай харилцах нь лалын ёсонд нийцэх тухай айлтгал ч нөлөөлөн Тэгүдэр хан Мамлюктай найрамдах бодлогыг эхлүүлэв<sup>4</sup>. 1282 оны 8-р сарын 22-нд Тэгүдэр ханаас Мамлюкын улсад илгээсэн захидалд хоёр улсын хооронд худалдаачид чөлөөтэй зорчих тухай саналыг онцгойлон тавьсан байв<sup>5</sup>. Худалдааны гол хэрэгсэл

<sup>1</sup> Ankhbayar Danuu. *İlhanlı Devleti'nde Vezaret*. Yayınlanmamış Doktora Tezi, Ankara Üniversitesi Sosyal Bilimler Enstitüsü Tarih Bölümü, Ankara: 2016, 164

<sup>2</sup> Shahâb âl-dîn ‘Abdâllâh bin Fazl âllâh Shîrâzî. *Tahrîr-e Târîx-e Vassâf*. Be qalam ‘Abd âl-Muhammed Âyîfî. Tehran: 1364, 67-68

<sup>3</sup> Muhammed bin Xâvandshâh Mîrxônd, *Târîx-e Ravzat âl-sefâ*. Tashih Jamshid Qiyānfar, J.V, Tehran: 1385, 4141

<sup>4</sup> Shahâb âl-dîn ‘Abdâllâh bin Fazl âllâh Shîrâzî. *Tahrîr-e Târîx-e Vassâf*. Be qalam ‘Abd âl-Muhammed Âyîfî. Tehran: 1364, 70

<sup>5</sup> Захидлын эхийг Ibn âl-‘Abrî. *Moxtasar Târîx-e âl-Dûvel*. Tarjumah ‘Abd âl-Muhammed Âyîfî. Tehran: 1377, 402. Гэхдээ энэхүү захидалд хэрэглэсэн лалын шашны холбогдолтой ойлголтууд хийгээд үг хэллэгүүд нь адилхан лалын улс болохын хувьд Ил хаант улсад дагаар орох, Ил хаадын нөлөөг хүлээн зөвшөөрүүлэх тулган шаардалтын шинжтэй болох тухай дэлгэрэнгүй судалгааг: Adel Al-louche. Teguder's Ultimatum to Qalawun. *International Journal of Middle East Studies*, Vol.22, No.4

болох зоос дэлдүүлэх ажиллагаа ч везир Шамс Ад-Дин Жувейнигийн удирдлагын доор явагдан зоосон дээрх Ил ханы нэр болон цолыг лалын ёсоор бичүүлж эхлэв<sup>1</sup>. Үнэхээр ч түүний үед дэлдүүлсэн зоосны ихэнхэд нь Тэгүдэр бус Ахмед хэмээх нэрийг тэмдэглэсэн байдаг<sup>2</sup>.

Ийнхүү Ил хаант улсын төрийн байгууламж нь лалын нөлөө ихсэхийн хэрээр үзэгтэн буюу Иран түшмэдийн гүйцэтгэх үүрэг ч шийдвэрлэх хэмжээнд хүрэх хандлага бий болов. Энэ бүхэнд Монгол ноёд язгууртны давхрааны дургүйцэл зөвүүцэл ч ихсэн ханхүү Аргуныг тойрсон уламжлалт үзэлтэй ноёдын бүлэглэл үүсэв. Уг бүлэглэлийн гол бай нь Тэгүдэр болохын хамт везир Шамс Ад-Дин Жувейни ч эн тэргүүн зайлуулагдах шаардлагатай нэгэн байлаа. 1284 онд Бухагийн удирдлагын доорх монгол ноёдын чуулган дээр “Ахмед Тэгүдэр хан лалын шашинд орж Чингисийн ургийг үл тоон сахиб-и диван тэргүүтэй лалуудад итгэл үзүүлж байна” хэмээн буруушаасан байдаг<sup>3</sup>. Угаас Абага ханыг Жувейни хордуулж алсан хэмээх цуурхал нэгэн үе дэгдэж асан<sup>4</sup> нь ханхүү Аргуны шадруудад аятай далим болов. 1282 оны 9-р сарын 24-нд Монгол ноёдоос Амир Али чинсан бээр хүү Кутлукшахын хамт ханхүү Аргунд бараалхан везир Шамс Ад-Дин Жувейни нь хаже Важих Ад-Динтэй хамтран Аргуныг хордуулан алах нууц төлөвлөгөө зохиосныг дуулгасан нь үйл явдлыг улам хурцатгав. Хилэглэсэн Аргун, Важих Ад-дины Кучан дахь гэрийг түйвээсний дараа Шамс Ад-Диныг баривчлан өөрт нь тушаахыг Тэгүдэр ханаас тулган шаардсанаар бослого эхлүүлэх үндсийг тавьжээ<sup>5</sup>. Бослогын дүнд ханхүү Аргун ялж 1284 оны 8-р сарын 10-нд Ил ханы ширээнд залрав. Ахмед Тэгүдэр болон везир Шамс Ад-Дин Жувейни нарыг цаазалсны<sup>6</sup> дараа төрийн байгууламжийг уламжлалт хэв маягт шилжүүлэх ажил явагдав. Аргун нь Тэгүдэр Ахмедын хаанчлалын үед төрийн хяналт Иран түшмэд буюу үзэгтэн хэсгийн гарт хэрхэн шилжсэн хийгээд түүний үр дагаварыг нүдээр үзсэн хүний хувьд төрийн хяналтыг Монгол ноёдын гарт төвлөрүүлэхийг эрмэлзэгч нэгэн байлаа. Тийм ч учир төрийн удирдлагад байх Ираны нөлөөг арилган уламжлалт

---

(Nov., 1990), 437-446-аас дэлгэрэнгүй үзнэ үү.

<sup>1</sup> Muhammed bin Xâvandshâh Mîrxônd, *Târîx-e Ravzat âl-sefâ*. Tashih Jamshid Qiyānfār, J.V, Tehran: 1385, 4140

<sup>2</sup> Нямаа, Б. *Монголын эзэнт гүрний зоос мөнгө, хаадын овгийн тамга*. Улаанбаатар: 2005, 215

<sup>3</sup> Shahâb âl-dîn ‘Abdâllâh bin Fazl âllâh Shirâzi. *Tahrîr-e Târîx-e Vassâf*. Be qalam ‘Abd âl-Muhammed Âyîfî. Tehran: 1383, 77-78; Muhammed bin Xâvandshâh Mîrxônd, *Târîx-e Ravzat âl-sefâ*. Tashih Jamshid Qiyānfār, J.V, Tehran: 1385, 4153

<sup>4</sup> Muhammed bin Xâvandshâh Mîrxônd, *Târîx-e Ravzat âl-sefâ*. Tashih Jamshid Qiyānfār, J.V, Tehran: 1385, 4134

<sup>5</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadâni. *Jâmi’ âl-tâwârîx*. J.II, 1383, 1131-1133

<sup>6</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadâni. *Jâmi’ âl-tâwârîx*. J.II, 1383, 1157-1161

нүүдэлчдийн төрийн системийг хэрэгжүүлж эхлэв. Анатолийн захирагчаар Хулажу ноён болон ханхүү Гайхату, Гүржийг Ажай ноён, Хорасан, Мазендаран, Кумис болон Рейн бүсийг ханхүү Газанд мэдүүлэв. Иргэний удирдлага буюу везирийн албан тушаалд Жалайрын Буха ноёныг томилсноор<sup>1</sup> Ил хаадын түүхэнд анх удаа цэрэг-иргэний захиргаа Монгол ноёдын хяналтанд бүрнээ орсон хэрэг болов. Өөрөөр хэлбэл Ил хан Аргун нь төрийн байгууламж дахь цэрэг-иргэний харилцааг зөвхөн нэг гарт атгуулах шинэ хувилбарыг санаачлан хэрэгжүүлэх бодлогыг явуулснаар төрийг найдвартай гараар буюу Монгол ноёдоор удирдуулан Иранчлагдах аюулаас сэргийлнэ хэмээн тооцсон бололтой байдаг.

#### 4. Монгол везир Буха ноёны амьдрал, үйл ажиллагаа

Аргун ханы эхэн үед везирийн албан тушаалд томилогдсон Буха ноён нь Жалайр аймгийн гаралтай нэгэн байв.

Жалайр аймгийн Уриат салбарын Углай хорчи нь (Ūglâyî qôrchî) Хүлэгү ханы дэргэд харуулын (qarâwûl) үүрэгтэйгээр Иранд анх ирсэн бөгөөд түүний Аруг (Ârûq), Буха (Bûqâ) нэртэй хоёр хөвүүн нь Абага ханы шадруудын тоонд (mulâzam-e bandagî) оржээ. Их хүү Аруг нь нэгэн үе Хубилай хааны зүг элчээр томилогдон эгж ирэхдээ хөх тамга (kûk tamghâ)<sup>2</sup> авчирч байв. Дараа нь тэрээр бүх шүүсэнчдийн (shûsunchîyân)<sup>3</sup> ахлах тушаалтны (tûsâmîshî)<sup>4</sup> үүрэг гүйцэтгэж байв<sup>5</sup>.

Рашид Ад-дины мэдээлж буйгаар Углай хорчи эрт нас барсан тул балчир хөвүүн Бухаг Абага хан ивээлдээ авч өсгөснөөс<sup>6</sup> харвал тэрээр 1260-аад оны эхээр Иранд төрсөн хоёрдугаар үеийн Монголчуудын төлөөлөл юм. 1279 онд Буха янаг (Înâq) цолтойгоор тамгач<sup>7</sup> (tamghâchî)-ын албан тушаалд томилогдсон бөгөөд үнэт үсний санг мэдэж байв<sup>8</sup>. тухайн үеийн үнэт үсний сан нь нарийн сан хэмээн нэрлэгдэж байсан бөгөөд Буха нь албан тушаалын зэрэглэлийн дагуу ал

<sup>1</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1156

<sup>2</sup> Амин Шарик үүнийг хөх тамга гэж үзжээ. Shamîs Sharîk Âmîn. *Farhang-e Estlâhât-e Dîvânî-ye Dôvrân-e Moghól*. Tehran: 1357, 206. Бидний үзэхээр энэ нь заргач болон шүүгч нарын хэрэглэдэг тамга бололтой. Чингис хааны үед Шихихутагт хариуцуулсан заргын дэвтрийг “Хөх дэвтэр” хэмээдэг байв. *Монголын нууц товчоо*. Эрхлэн хэвлүүлсэн Ш.Чоймаа, Улаанбаатар: 2006, 155

<sup>3</sup> Хүнс хариуцсан түшмэл. Shamîs Sharîk Âmîn. *Farhang-e Estlâhât-e Dîvânî-ye Dôvrân-e Moghól*. Tehran: 1357, 206

<sup>4</sup> Тушаал гаргагч түшмэл хэмээх утгатай. Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.IV, 1383, 2343

<sup>5</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.I, 1383, 70

<sup>6</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1110

<sup>7</sup> Худалдааны татварын түшмэл. Shamîs Sharîk Âmîn. *Farhang-e Estlâhât-e Dîvânî-ye Dôvrân-e Moghól*. Tehran: 1357, 101

<sup>8</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.I, 1383, 70

тамга хэрэглэх болжээ. Ийнхүү Буха их ноёдын зэрэгт багтжээ<sup>1</sup>. Абага ханы үеийн ноёдын зэрэг дэвийн жагсаалтанд Буха ноён 11-рт бичигдэж байсан бол түүний дүү Аруг нь 10-рт байв<sup>2</sup>.

Ил хаант улсын түүхэнд Бухагийн нэр нөлөө ихэссэн нь Ахмед Тэгүдэрийн үеэс эхлэлтэй. Ахмед Тэгүдэр Ил хант улсын хан ширээнд залрангуут зарим ноёд ханхүү Аргуныг дэмжин эсэргүүцэж эхлэв. Аргун ч Ил ханы ширээнд санаархаж байв. энэ нөхцөлд Тэгүдэр хан Аргуныг талдаа татахын тулд аргадах, эд зүйлээр шагнах аргуудыг хэрэглэж байлаа<sup>3</sup>. Үүний эсрэг зарим монгол ноёд Аргуныг дэмжихээ үргэлжлүүлсээр байсан нь бослогын тохироог бүрдүүлсэн үйл явц байлаа. Энэ торгон мөчид Буха ноён таллуудыг эвлэрүүлэх санаачлага гарган Тэгүдэрийн өмнөөс Аргунд хэдэнтээ бараалхсан авч тусыг эс олжээ<sup>4</sup>. Ханхүү Аргун Арак, Ширазын түмтүүд болон Багдадын удирдлагыг өөрт нь шилжүүлэхийг шаардахын зэрэгцээ Рей зэрэг төвийн мужуудын удирдлагыг хүчээр булаан авснаар<sup>5</sup> Ил хаант улсад дотоодын дайны аюул нүүрлэв.

Энэ үед Буха нь Ахмед Тэгүдэрийн дэргэд хүч нөлөөгөө улам ихэсгэсээр байв. Харин цэргийн удирдлага Алинак ноёны мэдэлд байсан нь талуудыг найрамдахад саад болж байлаа<sup>6</sup>. 1284 оны 5-р сарын 4-нд Казвини хотын дэргэдэх Акхожад талууд тулгаран байлдсанд ханхүү Аргун ялагдан ухарсанд Тэгүдэр хан Хорасан хүртэл аялан байлдах цэргийн захирагчаар Бухаг томилох зарлиг буулгасан нь Алинакын дургүйцлийг төрүүлэв<sup>7</sup>. Уг нөхцөлд Буха талуудыг эвлэрүүлэх байр суурь баримталж байв. Ийнхүү найрамдах саналыг Тэгүдэр ханд тавьж ятгасны эцэст түр хугацааны эвлэрэл зарлуулан улмаар 1284 оны 6-р сарын 3-нд Аргунтай уулзахаар замд гарчээ. Гэвч Бухаг замдаа явж байхад нь Тэгүдэр хан байр сууриа өөрчлөн цэргээ авч Дамган хүртэл давшив. Энэ мэдээг авсан Буха замаасаа буцан Тэгүдэр ханд бараалхаж удтал маргалдсаны эцэст талуудыг эвлэрүүлэх элчийн үүргээс авахуулжээ<sup>8</sup>. Ийнхүү Тэгүдэр хан гэнэтийн довтолгооноор

<sup>1</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1110

<sup>2</sup> Гияс ад-Дин б. Хумам ад-Дин ал-Хусейни Хондемир. *Муизз ал-ансаб*. анализ перевода Ш. Вохидова. Алма-аты: 2006, 83

<sup>3</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1128

<sup>4</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1130; Muhammed bin Xâvandshâh Mîrxônd, *Târîx-e Ravzat âl-sefâ*. Tashih Jamshid Qiyanfar, J.V, Tehran: 1385, 4141

<sup>5</sup> Shahâb âl-dîn 'Abdâllâh bin Fazl âllâh Shîrâzî. *Tahrîr-e Târîx-e Vassâf*. Be qalam 'Abd âl-Muhammed Âyûtî. Tehran: 1383, 75

<sup>6</sup> Ханхүү Аргун, Ахмед Тэгүдэрийг шүүмжлэхдээ Алинак ноёны харгис хатуу бодлогыг жишээ болгож байв. Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1139

<sup>7</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1139

<sup>8</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1140-1141

Аргуныг гэнэдүүлэн баривчилсан нь уулаасаа талуудыг эвлэрүүлэх байр суурийг баримталж асан Бухад хүнд цохилт болж улмаар ханхүү Жушкаб, Хулажу болон ойр төрлийн Аруг, Есүбуха, Тикна зэрэг язгууртнуудтай бүлэглэн цаашид хэрхэх тухай нууцаар зөвлөлдөв. Уг зөвлөгөөнд Буха “Ахмед Тэгүдэр хан лалын шашинд орж Чингисийн ургийг үл тоон сахиб-и диван тэргүүтэй лалуудад итгэл үзүүлэх болсон”<sup>1</sup> хэмээн зэмлээд “Аргуныг талархагч хэмээн сэжиглэгдсэн бүхэн нэн даруй цаазлагдах болсон”-оос үүдэн Тэгүдэрийг зайлуулж Аргуныг хан ширээнд залахын чухлыг сурталчлан зөвшөөрүүлэв<sup>2</sup>. Ийнхүү санал нэгдсэн ноёд гэнэтийн эргэлт гарган Алинак ноёныг устган хорионд байсан ханхүү Аргуныг суллан улмаар цэргийн удирдлагыг гартаа оруулсны дараа 7-р сарын 3-нд Бухагийн гэрт цаашид хэрхэх талаар дахин зөвлөлдөв<sup>3</sup>. Ийнхүү хүчний харьцаа өөрчлөгдсөн тул Ил ханыг сонгох асуудал хурцаар тавигджээ. Эдгээр хан хөвүүд, ноёд Аргуныг суллахаар санал нэгдсэн боловч шинэ Ил ханаар хэнийг сонгох тухайд харицан адилгүй байр суурь баримталж байв. Буха ноён Аргуныг дэмжиж байсан бол Аруг ноён Жушкабыг, Тикна ноён Хулажуг Ил ханаар өргөмжлөх байр суурьтай байв. Талуудын хооронд маргаан туйлдаа хүртэл ширүүсэн Аргун нэрээ татаж авах хүртэл үргэлжлэв. Энэ үед Буха ноён босож Абага ханы өвийг Аргун л замгамжлах эрхтэйг дурдаад энэ үйл хэргийн төлөө үхэхэд ч бэлэн буйгаа дурдсанаар бүгд Аргуныг хан сонгохоор зөвшөөрчээ<sup>4</sup>.

Ийнхүү 1284 оны 8-р сарын 11-нд Аргун Ил ханы ширээнд заларсны дараа төрийн удирдлагад Иран болон лалын элементийг халж уламжлалт Монгол төрийн хэв маягийг чухалчлав. Улсын везирийн тушаалд Буха ноёныг *vazîr-e memâlek* цолтойгоор томилсон бөгөөд 9-р сарын 15-нд Ил ханы зүгээс их хэмжээний үнэт эдлэлээр шагнаж улсын засаглал болон бодлогыг бүрэн эрхтэйгээр хөтөлж явуулах эрхийг олгожээ<sup>5</sup>. 1286 оны 2-р сарын 23-нд Хубилай хааны илгээсэн зарлигийн ёсоор Бухад чинсангийн хэргэм соёрхсоноос<sup>6</sup> хойш Бухай чинсан хэмээн түүх бичлэгт тэмдэглэгдэх болов. Ил хан Аргуны зүгээс Бухад 9 гэмээс хэлтрүүлэх, түүний дэргэд Ил ханаас бусад хэн ч бай зөвшөөрөл авалгүйгээр ярихгүй байх,

<sup>1</sup> Shahâb âl-dîn ‘Abdâllâh bin Fazl âllâh Shîrâzî. *Tahrîr-e Târîx-e Vassâf*. Be qalam ‘Abd âl-Muhammed Âyîfî. Tehran: 1383, 77-78; Muhammed bin Xâvandshâh Mîrxônd, *Târîx-e Ravzat âl-sefâ*. Tashih Jamshid Qiyāfar, J.V, Tehran: 1385, 4153

<sup>2</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi’ âl-tâwârîx*. J.II, 1383, 1143

<sup>3</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi’ âl-tâwârîx*. J.II, 1383, 1144

<sup>4</sup> Талуудын хоорондын маргаан Буха ноён Тикна ноён луу сэлэм барин дайрах хүртэл ширүүссэн гэдэг. Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi’ âl-tâwârîx*. J.II, 1383, 1146-1147

<sup>5</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi’ âl-tâwârîx*. J.II, 1383, 1156-1157

<sup>6</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi’ âl-tâwârîx*. J.II, 1383, 1162

везирийн ал тамга, улаан дардас дарагдаагүй бол ямар ч үйл ажиллагаа явагдахгүй байх, Бухагийн тамгагүй ямар ч бичиг Ил ханд өргөн баригдахгүй байх зэрэг тусгай эрхүүдийг олгожээ<sup>1</sup>. Тухайн үеийн нэрт зүйтгэлтнүүдээс Желал Ад-Дин Малек Семнани, Хусам Ад-Дин Казвини ба Фахр Ад-Дин Моставфи нар везирийн орлогчоор томилогдон Бухагийн дэргэд байнга алба хаших болов<sup>2</sup>. Бухагийн төрсөн ах Аруг ноён Багдадын захирагчаар 1285 оны 9-р сарын 12-нд томилогдон<sup>3</sup> 1286 оны 3-р сард Багдадад хүрэлцэн ирж албандаа оров<sup>4</sup>.

Буха чинсан ийн везирийн үүрэгт ажлаа эхлэх үед улс оронд эдийн засгийн томоохон хямрал үүссэн байлаа. Улсын санд буй бэлэн мөнгө 150 түмээс үл хэтрэх бөгөөд Аргун ханы зарлигаар эрдэнэсийн санг Сугурлулт нүүлгэн шилжүүлсэн боловч хээл хахууль, үргүй зардал зэрэг шалтгаанаар бараг үгүйрэн хоосроход тулав<sup>5</sup>. Үүний дээр хээл хахууль, хөрөнгө завших явдал ч гааран улсын сангийн орлого үлэмж буурчээ. Тухайлбал, ордны хүнсний татвар (*âsh-e ôrdû*) бүх мужуудаас хураагдаж байсан боловч мужийн захирагч, татварын түшмэл, ордны даамал нар үгсэн хуйвалдаж дундаас нь завшдаг тул тогтоосон хэмжээнд огт хүрэхгүй байв<sup>6</sup>. Буха чинсан энэ мэтийн алдагдлыг нөхөхийн тулд татварын хэмжээг ихэсгэн тогтоосон хэмжээг хүч дайчлан хураах арга хэмжээг авч эхэлжээ. Кирман мужийн нийт татвар нь 600 мянган динар байсныг 690 мянган динар болгон өсгөжээ. Уг татварыг дотор нь ангилан үзвэл ордны зардал 100 мянга, цэргийн зардал 120 мянга, хүнс 90 мянга, ууш 30 мянга, харуул ангийн зардал 10 мянга, цайз, цамхагийн засварт 10 мянга, өртөөний зардал 10 мянга, кофены зардал 10 мянга болон диваны үйл ажиллагааны зардал 10 мянга хэмээн хуваарилагдаж байв<sup>7</sup>. Энэ үед Анатолийн эдийн засгийн амьдрал ч хүнд татварын улмаас хямарч эхлэв. 1285 онд Анатолид томилогдон ирсэн ханхүү Хулажу болон Гайхатугийн зүгээс оноогдсон тагар татварын хэмжээ нь Анатолийн Селжукийн улсын 50 жилийн туршид хураасан баялгийн хэмжээнээс давж байлаа. Үүнээс болж нэг тагарын

<sup>1</sup> Shahâb âl-dîn ‘Abdâllâh bin Fazl âllâh Shîrâzî. *Tahrîr-e Târîx-e Vassâf*. Be qalam ‘Abd âl-Muhammed Âyîtî. Tehran: 1383, 129

<sup>2</sup> Shahâb âl-dîn ‘Abdâllâh bin Fazl âllâh Shîrâzî. *Tahrîr-e Târîx-e Vassâf*. Be qalam ‘Abd âl-Muhammed Âyîtî. Tehran: 1383, 129; Muhammed bin Xâvandshâh Mîrxônd, *Târîx-e Ravzat âl-sefâ*. Tashih Jams-hid Qiyanfar, J.V, Tehran: 1385, 4172

<sup>3</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi’ âl-tâwârîx*. J.II, 1383, 1162

<sup>4</sup> Kamâl âl-dîn ‘Abd âl-Razzâq Ìbn Fûtî. *Âl-Havâdis âl-Jâmi’a*. Terjeme ‘Abd âl-Muhammed Âyîtî. Tehran: 1381, 269

<sup>5</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi’ âl-tâwârîx*. J.II, 1383, 1350

<sup>6</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi’ âl-tâwârîx*. J.II, 1383, 1505-1506

<sup>7</sup> Nâser âl-dîn Monshî Kermânî. *Semt âl- ‘Alî âl-Lihzrat âl- ‘Alîyâ*. Tashih ‘Abbâs Ìqbâl Âstîyânî, Tehran., 1368, 57

үнэ 70 дирхемийг давав. Ийн ноогдуулсан тагарын хэмжээ гүйцээгүйгээс болж Анатолийн Селжукийн улсын султаны туслах Мужир Ад-Дин Амир шах болон Бэглэрбэй Азиз Ад-Динаг засаглан шийтгэх тушаал гарсан боловч дараа нь Ил ханы ордноос ирсэн зарлигийн ёсоор өршөөл үзүүлсэн байна<sup>1</sup>. Фарс мужид өмнө нь Сайн эзний (Sâ'in İjen) буюу Хүлэгү ханы тусгай хэрэгцээнд зориулан жилд 100 мянга, Атабекэд зориулж 50 түм ба түүний туслахуудад зориулан 20 түмэн мөнгөний татвар авдаг байсан бол Буха чинсан өмнөх жилүүдийн үлдэгдэл хэмээн 500 түмийг нэмэн оноосонд нэлээдгүй хүч зарцуулж байж хураан нийлүүлжээ<sup>2</sup>. Буха чинсан нь ийнхүү хүнд татварын бодлого болон буддын шашны шүтлэгээсээс болж тухайн үеийн сурвалжуудад сөргөөр дүрслэгдсэн байдаг<sup>3</sup>.

Энэ үеэр буддын гүн шүтлэгт Аргун хан төрийн хэргээс хөндийрөн шашны үйл ажиллагаанд илүү анхаарах болсноос<sup>4</sup> үүдсэн улс төрийн орон зай нь Бухад аятай шалтгаан болов. Ах Аругтайгаа нийлэн төрийн ажлыг атган богино хугацааны дотор хэмжээгүй эрхт нэгэн болов. Түүгээр ч үл барам нэр, нөлөөний хувьд Аргун хантай өрсөлдөж эхэлсэн аж. Тухайлбал, Тебризийн захирагч Али нь Аргун ханы зарлиг гэрэгэ бүхий элч ч байсан Бухагийн ал тамга үгүй бол хүлээж авахаа байсан аж. Үүнээс болж ардын олонх нь Бухаг Аргун ханаас илүүд үзэх хандлага ч буй болов<sup>5</sup>. Үнэхээр ч Бухагийн нэр хүнд, нөлөө маргахын араггүй өсөж иржээ. Бар Хебраесийн онцгойлон тэмдэглэсэнээр Буха нь ордны бүх хэрэг, хаад, захирагчид хийгээд бүх албан хаагчдыг толгойлсон онцгой эрх мэдэлд хүрсэн ажээ<sup>6</sup>. Үүний дээр Ил хаант улсын түүхэн дэхь бусад везирүүдээс ялгагдах нэг гол онцлог нь цэргийн онцгой эрх мэдэл нь юм. Тэрээр везир буюу иргэний удирдлагын дээд эрхийг барьж байгаа хэдий ч ил хаадын арми дахь монгол цэргийн (cherîk-e bozorg) жанжны албан тушаалаа ч үргэлжлүүлэн хашсаар байв<sup>7</sup>. Цэргийн эрхтний хувьд тэрээр дайн байлдааны үйл хэрэгт ч идэвхтэй оролцож байлаа. 1288 оны 5-р сард Кипчакийн хан Тамай Тогтай Муртад 5 мянган морин цэргийн хүчээр

<sup>1</sup> Kerîmüddin Mahmud-i Aksarayî, *Müsâmeretü 'l-Ahbâr*, Çev. Mürsel Öztürk, TTK, Ankara: 2000, 115-117

<sup>2</sup> Shahâb âl-dîn ' Abdâllâh bin Fazl âllâh Shîrâzî. *Tahrîr-e Târîx-e Vassâf*. Be qalam ' Abd âl-Muhammed Âyâtî. Tehran: 1383, 126-127

<sup>3</sup> Shîrîn Bayânî. *Dîn va dowlat dar Îrân 'ahd-e Moghól*. J.II, Tehran: 1381, 421

<sup>4</sup> Тухайлбал 1288 оны 4-р сарын 11-нд Ил ханы ордонд Буддагийн шарил хэмээн нэрлэгдэх нэгэн ясны хэлтэрхийг авчрах үед Аргун хан ихэд баясан олон хоног дамнасан ёслол, найр үйлдүүлж байв. Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1163-1164

<sup>5</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1167

<sup>6</sup> Abu'l-Farac, Gregory. *Abu 'l-Farac Tarihi*. Çeviren Ömer Riza Doğrul, C. II, TTKY, Ankara: 2000, 622

<sup>7</sup> Muhammed bin Xâvandshâh Mîrxônd, *Târîx-e Ravzat âl-sefâ*. Tashih Jamshid Qiyandar, J.V, Tehran: 1385, 4172

Дербендийн орчимд Ил хаадын хилд халдан тэр хавийн ортаг болон бусад худалдаачдыг түйвээж буй мэдээ ирсэн даруйд Буха чинсан нь Гончигбал ноёнттой хамтран манлай цэргийг удирдаж дайсан этгээдийг үлдэн хөөж байв<sup>1</sup>.

Буха ийнхүү цэргийн эрх мэдлээ улам бататгахын тулд их цэргийн болон инжү мужуудын захиргааг шилжүүлэх авах хүсэлт гаргасан нь Аргун ханыг сэрэмжлүүлэхэд хүргэв<sup>2</sup>. Бухагийн хурдан хугацаанд хүчирхэгжсэн явдал нь бусад монгол ноёдын болгоомжлолыг ч өөрийн эрхгүй төрүүлж эхлэв. Үүний дээр Бухагийн бардам зан, бүхнийг дураараа шийдэх байдалд дургүйлхсэн Тогочар, Гончигбал, Жуши, Орду хиа болон Долоодой идээч нарын ноёд Тогоон болон Султан идээчийн удирдлагаар бүлэглэл үүсгэж эхлэв<sup>3</sup>. Энэ үеэр буюу 1286 онд Багдадаас гурван хүн Бухагийн ах Аругийн тухай гомдол мэдүүлэхээр ирсэн даруйдаа Аргун ханы хамгаалалтад орсон хэдий ч Бухагийн зарлигаар өчиг өгч амжилгүй цаазлагдсан<sup>4</sup> байна. Гэтэл эдгээрийн нэг нь болох Мажд Ад-Дин Ибн ал-Асир нь хан хүү Гайхатугийн инжү харьяат байсан тул Гайхату ихэд хилэгнэн Аругийн шадар хаже Харун хэмээгчийг энэ хэрэгт буруутгаж Аладаг дахь өөрийн ордондоо цаазаар авсан явдал<sup>5</sup> нь дээр өгүүлсэн ноёдын бүлэглэлийг зоригжуулахад хүргэжээ. Вассафын Шираз хотын нэр хүнд бүхий хүмүүсийн амнаас сонссоноор бол Бухагийн орлогч Сейд Фахр Ад-Дин, 1286-1287 онд Тогоон ноёныг Кухастан мужийн шахнегийн үүрэг гүйцэтгэж байх үед нь нэгэн өмчийн хэргээс болж бэрээгээр 17 удаа занчих шийдвэр гаргажээ. Хилэгнэсэн Тогоон ноён Аргун хан бараалхан уг 17 удаагийн занчилт нь Ил ханы шадар 70 ноёдыг заналхийлсэн утгатай хэмээн гомдол мэдүүлэв<sup>6</sup>. Гэтэл Буха ч өөрийн туслахаа хамгаалан уг шийтгэлийг Их засагийн ёсоор дахин оноолгосон байна<sup>7</sup>. Ийнхүү Бухагийн ах Аругийн байр суурь ганхаж эхэлсэн нь аятай далим болж тэмцэгчдийн гол бай нь Аруг болов.

Рашид Ад-Дины мэдээлж буйгаар Аруг нь Багдадад хаан шиг тансаг амьдралд умбаж байсан аж<sup>8</sup>. Багдадын хуучин захирагч ‘Ата Малек Жувейнигийн туслах байсан Кутлугшах тэргүүтэй монгол ноёдтой таарамжгүйн улмаас Тебриз рүү

<sup>1</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1167; Faruk Sümer. İlhanlı Hükümdarlarından Abaka, Argun Hanlar ve Ahmed-i Celayir, *Belleten*, C.LIII, Sayı 206, 1989, 186

<sup>2</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1167

<sup>3</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1166

<sup>4</sup> Abu'l-Farac, Gregory. *Abu'l-Farac Tarihi*. Çeviren Ömer Riza Doğrul, C. II, TTKY, Ankara: 2000, 622

<sup>5</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1162-1163

<sup>6</sup> Shahâb âl-dîn 'Abdâllâh bin Fazl âllâh Shîrâzî. *Tahrîr-e Târîx-e Vassâf*. Be qalam 'Abd âl-Muhammed Âyâtî. Tehran., 1383, 130-131

<sup>7</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1166

<sup>8</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1166

хөөгдсөн Са'ад ал-Довла<sup>1</sup> нь Орду хиа ноёны дэмжлэгээр Аргун ханы итгэлийг олсон амжилтандаа дулдуйдан Аругийн эсрэг явуулга хийж эхлэв<sup>2</sup>. Тухайн үеийн Багдадын удирдлага нь хүнд татварын бодлого, ургац алдалт, өлсгөлөн болон өвчлөл тархсанаас болж амжилтгүй хэмээн хэлүүлэхэд хүрээд байв. Мөнгөний гүйлгээнд ч хүндрэл учирсан тул үе үе зоосны сорьыг өөрчлөхөөс аргагүйд хүрчээ. Энэ бүхний дүнд сангийн орлого буурсан тул худалдаачдаас их хэмжээний мөнгийг хүч хэрэглэн дайчлан гаргуулах зэргээр аргацаахыг оролддог болов<sup>3</sup>. Са'ад ал-Довла нь Багдадын энэхүү байдлыг Аргун ханд айлтгасны эцэст 1288 онд Орду хиа ноёнттой хамт шалгалт хийх эрх авчээ. Хийсэн шалгалтын үр дүнд Буха болон Аругийг гол буруутнаар тодруулан тухайлбал Аруг нь жил бүр 500 түмэн мөнгийг санд тушаалгүй хувьдаа завшсан тухай айлтгал үйлдэн Аргун ханд өргөн барив. Хилэгнэсэн Аргун хан Аругийг албан тушаалаас нь огцруулсны дараа 1288 оны 6-р сарын 6-нд Орду хиаг Багдадын захирагчаар томилов<sup>4</sup>.

Ийнхүү Бухагийн нэр хүнд, сүр хүч ганхаж эхлэв. Энэ нөхцөлд хамгийн анхны довтолгооныг Тогоон ноён үйлдэв. Тэрээр бусад монгол ноёдод хандан Буха нь Ахмед Тэгүдэрээс урвасан шигээ Аргун ханаас ч нэг өдөр урвах болно хэмээн өдөөн хатгалга хийж эхлэв<sup>5</sup>. Төд удалгүй Тогочар ноёны туслагч Садр Ад-Дин Занжани ч уг өгүүллийг давтсаны эцэст Буха нь Тебризийн захирагч амир Алитай хамтран Аргуны эсрэг хуйвалдаан сэдсэн тухай мэдээ тархаав<sup>6</sup>. Ийн улс орны өнцөг бүрээс Бухагийн тухай гомдол ширүүссэнээр бүгд Бухагаас зайгаа барьж эхлэв. Тэр ч байтугай нэг удаа Аладаг дахь Ил ханы ордонд болсон нэгэн найран дээр зарим ноёд Бухад хандан агсан тавьсанд Бухаг хамгаалсан нэг ч хүн гараагүй гэдэг<sup>7</sup>. Энэ нөхцөлд Аргун хан ч арга хэмжээ авч Бухагийн диван болон данс дэвтрүүдийг битүүмжлэн бүх туслахуудыг нь диван дахь ажлаас халсан тухай зарлиг гаргажээ<sup>8</sup>.

<sup>1</sup> Kamâl âl-dîn 'Abd âl-Razzâq İbn Fûtî. *Âl-Havâdis âl-Jâmi'a*. Terjeme 'Abd âl-Muhammed Âyîfî. Tehran., 1381, 270

<sup>2</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1165

<sup>3</sup> Mustafa Uyar. İlhanlı Devletinde Yahudi Bir Vezir: Sa'düddevele, *AÜDTCTAD*, C. 21, Sayı 33, Ankara: 2003, 133

<sup>4</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1165; Muhammed bin Xâvandshâh Mîrxônd, *Târîx-e Ravzat âl-sefâ*. Tashih Jamshid Qiyānfar, J.V, Tehran: 1385, 4176; Kamâl âl-dîn 'Abd âl-Razzâq İbn Fûtî. *Âl-Havâdis âl-Jâmi'a*. Terjeme 'Abd âl-Muhammed Âyîfî. Tehran: 1381, 273

<sup>5</sup> Shahâb âl-dîn 'Abdâllâh bin Fazl âllâh Shîrâzî. *Tahrîr-e Târîx-e Vassâf*. Be qalam 'Abd âl-Muhammed Âyîfî. Tehran: 1383, 131

<sup>6</sup> Muhammed bin Xâvandshâh Mîrxônd, *Târîx-e Ravzat âl-sefâ*. Tashih Jamshid Qiyānfar, J.V, Tehran: 1385, 4176

<sup>7</sup> Shahâb âl-dîn 'Abdâllâh bin Fazl âllâh Shîrâzî. *Tahrîr-e Târîx-e Vassâf*. Be qalam 'Abd âl-Muhammed Âyîfî. Tehran: 1383, 131

<sup>8</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1176

Буха чинсан ч өөрийг нь нөмрөн ирж буй аюулын эсрэг тэмцэх цорын ганц арга бол бослого гаргах явдал хэмээн шийдсэний дараа хахууль, бэлэг өгөх замаар чухал байр суурь бүхий монгол ноёдыг талдаа татаж эхлэв. Ах Аругтай хамтран Жалайр аймгийн гаралтай түмтийн захирагч Хинду ноёны хүү Курмиши, зэвсгийн даамлуудаас Ужан, Хадан элч, Наяа ноёны хүү Занги, Өлзий хатны ордны захирагч бөгөөд мянгатын ноён Майжу, Туглуг Харауна, Газан баатар, дөрвөн мянгатын захирагч Ишиг Тугли болон өөр аймгаас Баян, Алгу битикчийн хөвүүн Мигритай, Жириг битикчи тэргүүтэй цөөн бус хүмүүсийг талдаа татав. Хамгийн сүүлд Евфрат мөрний эрэгт сууж байсан ханхүү Жушкабт нууцаар элч илгээн Аргун ханы эсрэг бослогод оролцохыг санал болгоод амжилттай болсон нөхцөлд Жушкабыг Ил хан өргөмжлөхийг амласан нь уг төлөвлөгөөг нураахад хүргэв. Ханхүү Жушкаб уг ноёдоор мөчэлга<sup>1</sup> үйлдүүлсний дараа шууд Аргун ханд дамжуулан хуйвалдааныг илчлэв. Энэ үеийг хүртэл завшаан хайж байсан Султан идээч, Долоодой болон Тогоон нар гавшгайлан хөдөлж Өлзий хатны өргөөнд нуугдаж байсан Бухаг баривчлан авсны дараа Аргун ханы зарлиг ёсоор 1289 оны 1-р сарын 16-нд Кур мөрний хөвөөнд цаазлан толгойг нь Цагаан нэрт гүүрнээс өлгөжээ<sup>2</sup>. Тун удалгүй Бухагийн хөвгүүдээс Абачи, Малек, Тархантөмөр, Кутлугтөмөр, ах Аруг, шадруудаас амир Али тамгач, Хусам Ад-Дин Казвини, Имам Ад-Дин Мунажжем, Баха Ал-Довла Абу Ал-Карамид Насрани, Газан, Ужан, Занги тэргүүтэй хүмүүсийг ч засаглан цаазлав<sup>3</sup>. Ийнхүү Буха нь Ил хаант улсын түүхэн дэх цорын ганц Монгол везир боловч 5 жилийн туршид везирийн үүргийг гүйцэтгэсний эцэст нь мөн л бусад везирүүдийн адил ноёд-везирийн зөрчлийн золиос болжээ.

<sup>1</sup> Талууд ямар нэгэн ажлыг хамтран гүйцэтгэхээ харилцан тохирч хэрэв хэн нэгэн нь оногдсон үүргээ биелүүлээгүй бол ял шийтгэл хүлээх тухайг баталгаажуулсан гэрээ бичиг. Shamîs Sharîk Âmîn. *Farhang-e Estlâhât-e Dîvânî-ye Dôvrân-e Moghól*. Tehran: 1357, 230-231

<sup>2</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1168-1171; Shahâb âl-dîn 'Abdâllâh bin Fazl âllâh Shîrâzî. *Tahrîr-e Târîx-e Vassâf*. Be qalam 'Abd âl-Muhammed Âyûfî. Tehran: 1383, 139

<sup>3</sup> Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. J.II, 1383, 1168-1171

## Дүгнэлт

Ил хан Тэгүдэрийн хаанчлалын үр дүнд үзэгтэн хэсэг болох Шамс Ад-Дин Жувейни тэргүүтэй Иран гаралт түшмэд үлэмж хүчирхэгжин Монгол ноёдын эрх нөлөөг хязгаарлах хандлагатай болсон тул Аргун ханы үед Монгол ноёд төрийн систем дахь тэнцвэрт байдлыг хангах оролдлого хийв. Үр дүнд нь хүчирхэг монгол ноён Бухаг төрийн везирээр өргөмжлөв. Гэвч цэрэг-улс төрийн эрхтэнд везаретийн мэдлийг давхар эдлүүлснээр Ил хаадын түүхэнд цорын ганц танfiz ангиллын везир гарч ирэх нөхцлийг хангав. Ялангуяа Буха чинсан нь везирээс гадна арми дахь албан тушаал, эрх мэдлээ хослуулан ашигласнаар Ил хантай эн зэрэгцэн бүр зарим талаар давж гарсан нэгэн болов. Мөн цэргийн гаралтай язгууртан болох Буха нь везирийн албан үүрэг болох улс орны эдийн засгийг тохинуулах ажилдаа цэргийн сурвалжтаны үндсэн шинж болох хүч хэрэглэх, албан татвар нэмэх байдлаар төрийн санг арвижуулах гэсэн оролдлого нь Иран түшмэдийн дургүйцлийг ч өдөөв. Энэ байдлыг засах гэсэн Аргун ханы оролдлого нь везир сайд нь Ил ханыг унагах оролдлого-зэвсэгт бослогыг өдөөсөн Ил хаант улсын түүхэнд цорын ганц тохиолдлыг бий гаргаж ирсний хамт төрийн удирдлагад Монгол-Ираны хүчний тэнцвэрт байдлыг хангах нь хичнээн чухал болохыг ч давхар ойлгуулж өгсөн юм. Үр дүнд нь Ил хаадын түүхийн туршид везирийн системийг төгөлдөржүүлэх, хүчний харьцааг тэнцвэржүүлэх үүднээс Ойрх дорнод дахь шашны цөөнх болох еврей угсаат везир, везарет ба сахиб-и диваныг тус тусдаа эрхэлсэн хос везир, адил эрх, үүрэг бүхий хос везир зэрэг олон хувилбар туршигдсан билээ.

**Abstract:** Khorasan diwanate served as a model for organising civil administration after the establishment of Il-Khanate dynasty by Hulagu, the younger brother of YekeMongyol Ulus Emperor Möngke, in the year of 1256. The distinctive feature of this newly-established civil administration was the fact that officials and financiers from Iranian origin were appointed to the head of vizierate office. But the socio-political life of Il-Khanid state depended heavily on how Il-Khans could balance the powers of viziers and Mongol noyans as the former was at the outset in deep conflict with latter's interest. In this article I deal with some characters of Il-Khanate vizierate and then examine activities and results of the vizierate directed by Buqachingsang, one of Mongol noyans of Il-Khan Argun.

## Ном зүй

1. âl-‘Abrî, İbn. *Moxtasar Târîx-e âl-Düvel*. Tarjumah ‘Abd âl-Muhammed Âyîfî. Tehran: 1377
2. Abu’l-Farac, Gregory. *Abu’l-Farac Tarihi*. Çeviren Ömer Riza Doğrul, C. II, TTKY, Ankara: 2000
3. Aknerli Grigor. *Okçu Milletin tarihi*. Çeviren Hrant Andresyan. İstanbul: 1954
4. Aksarayî, Kerîmüddin Mahmud-i. *Müsâmeretü’l-Ahbâr*, Çev. Mürsel Öztürk, TTK, Ankara: 2000
5. ‘Alâ’ âl-Dîn ‘Atâ Malek Jûwaînî. *Târîx-e jahân gûshâ-yî*. Tashîh Muhammed bin ‘Abd âl-Vahâb Qazvînî. J. I-III, Tehran: 1385
6. Allouche, Adel. Teguder’s Ultimatum to Qalawun. *International Journal of Middle East Studies*, Vol.22, No.4 (Nov., 1990), 437-446
7. Âmîn, Shamîs Sharîk. *Farhang-e Estlâhât-e Dîvânî-ye Dôvrân-e Moghól*. Tehran: 1357
8. Ankhbayar Danuu. *İlhanlı Devleti’nde Vezaret*. Yayınlanmamış Doktora Tezi, Ankara Üniversitesi Sosyal Bilimler Enstitüsü Tarih Bölümü, Ankara: 2016
9. *Azərbaycan tarixi (XIII-XVIII əsrlər)*, C.III, “Elm”, Bakı: 2007
10. Bahiş, Âhmed Furûgh. Se Dîvân-e Mohim dar ‘Ahd-e İlxânî, *KMTC*, Shomare 81-83, Tehran: 1383
11. Banâkatî, Fahr âl-Dîn Dâvûd. *Târîx-e Banâkatî*. Tashîh Jafar Sh’iâr, Tehran: 1378
12. Bayânî, Shîrîn. *Dîn va dowlat dar İrân ‘ahd-e Moghól*. J.II, Tehran: 1381
13. Fûtî, Kamâl âl-dîn ‘Abd âl-Razzâq İbn. *Âl-Havâdis âl-Jâmi’a*. Terjeme ‘Abd âl-Muhammed Âyîfî. Tehran: 1381
14. Galstyan A.G. *Ermeni Kaynaklarına göre Moğollar*. Çeviren İlyas Kamalov, İstanbul: 2005
15. İbn Bibi. *El Evamirü’l-Ala’iye Fi’l-Umuri’l-Ala’iye (Selçuk name)*. Çev. Mürsel Öztürk, TCKBY, Ankara: 1993
16. İlhan Erdem, “Türkiye Selçuklu-İlhanlı İktisadî, Ticarî İlişkileri ve Sonuçları”, *Ankara Üniversitesi Dil, Tarih ve Coğrafya Fakültesi Tarih Bölümü Tarih Araştırmalar Dergisi*, sayı 33, cilt 21, Ankara: 2003
17. Kermânî, Nâser âl-dîn Monshî. *Semt âl-‘Alî âl-Lihazrat âl-‘Alîyâ*. Tashih ‘Abbâs İqbâl Âshtîyânî, Tehran: 1368
18. Kiragos. Ermeni Müellifi Kiragos’un Vakayinamesi. (Edt. Hasan Oktay). *Ermeni Kaynaklarında Türkler ve Moğollar*. İstanbul: 2007

19. Lambton, Ân Swynford. *Tedâvûm ve tahavvûl dar Târix-e Miyaneh-e Îrân*. Terjume Yâkûb Âjand, Tehran: 1386
20. Al-Mâzandarânî, ‘Abd âllâh bin Muhammed bin Qîyâ. *Resâleh-e Falakîyyah*, Tashih Walter Hinz, chaphane-e Frans Ştayner, Wiesbaden: 1952
21. Mâvardî, Âbû âl-Hasan ‘Alî bin Muhammed bin Habîb âl-Basrî âl-Baghdâdî. *Ketâbûl-Ahqâmi’s-Sultânîyyeh*, Matbaatû’l Vatan, Misr: 1298
22. M.Minovi and V.Minorsky, “Nasir al-Din Tusi on Finance”. *BSOAS*, vol 10, No.3, London: 1940, 755-789
23. Mîrxônd, Muhammed bin Xâvandshâh, *Târix-e Ravzat âl-sefâ*. Tashih Jamshid Qiyanfar, J.V, Tehran: 1385
24. Nahjûvânî, Muhammed bin Hindûshâh. *Dastûr âl-kâteb fi t’ayîn âl-marâteb*. Tashih Abdolkarîm ‘Alîôglî ‘-Alizâdeh, J.II, Moskva: 1976
25. Özgüdenli, Osman G. İlhanlı Hükümdarı Ebu Sa’id Han’a Ait Dört Yarlîg. *Belleten*, C. LXIX, sayı 254, Nisan: 2005
26. Philips E.D. *The Mongols*, Publisher Thames and Sudson, London: 1969
27. âl-Qalqashandî, Âhmed bin ‘Alî. *Subh âl-Â’shâ fi Sanâ’ayeh âl-Ânshâ’*. Sharh Muhammed Huseyîn Shams âl-Dîn. J.IV Beyrut., 1987
28. al-Qashani, Abolqasim Abdollah bin Mohammad. *Târix-e Ôljâitû*. Ehtamam Mohin Hambeli. Tehran: 1384
29. Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi’ âl-tâwârîx*. Tashih Muhammed Rûshan, Mustafî Mûsavî. J.I-IV, Tehran: 1383
30. Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Mukâtabât-e Rashîdî*. Tashih Muhammed Shefih, Lahor: 1945
31. Shîrâzî, Shahâb âl-dîn ‘Abdâllâh bin Fazl âllâh. *Tahrîr-e Târix-e Vassâf*. Be qalam ‘Abd âl-Muhammed Âyîtî. Tehran: 1364
32. Shîrâzî, Shahâb âl-dîn ‘Abdâllâh bin Fazl âllâh. *Tahrîr-e Târix-e Vassâf*. Be qalam ‘Abd âl-Muhammed Âyîtî. Tehran: 1383
33. Soudavar, Âbol’alâ. Farman of The İl-Khan Gaykhatu, *Art of The Persian Courts*, New York: 1992
34. Spuler, Bertold. *İran Moğolları: Siyaset, İdare ve Kültür (İlhanlılar Devri 1220-1350)*. Çeviren Cemal Köprülü, TTKY, Ankara: 1987
35. Sümer, Faruk. İlhanlı Hükümdarlarından Abaka, Argun Hanlar ve Ahmed-i Celayir, *Belleten*, C.LIII, Sayı 206, 1989
36. Togan, Zeki Velidi. *Umumi Türk Tarihine Giriş*. İstanbul: 1981

37. Uyar, Mustafa. İlhanlı Devletinde Yahudi Bir Vezir: Sa'düddevle, *AÜDTCFTAD*, C. 21, Sayı 33, 2003
38. "Vezir". *İslam Ansiklopedisi*, C.XIII, İstanbul: 1986
39. Xavândamîr, Ghîyâs âl-dîn Humâm âl-dîn. *Âsâr âl-mulûk*. Tashih Mir Hashim Muhaddis, Tehran: 1372
40. Xavândamîr, Ghîyâs âl-dîn Humâm âl-dîn. *Târîx-e Habîb âl-sîyar*. Tashih Muhammed Dabîr Sîyâqî, J. III, Tehran: 1380
41. Zeydân, Corcî. *İslam Uygurlukları Tarihi*, çev. Nejdet Gök, Cilt I, İletişim Yay, İstanbul: 2004
42. *Монголын нууц товчоо*. Эрхлэн хэвлүүлсэн Ш.Чоймаа, Улаанбаатар: 2006
43. Нямаа, Б. *Монголын эзэнт гүрний зоос мөнгө, хаадын овгийн тамга*. Улаанбаатар: 2005
44. Петрушевский, И.П. Иран, Азербайжан Хулагугийнхний ноёрхолд (1256-1353). *Монгол-Татаарууд Ази, Европт*. Улаанбаатар: 1984
45. Хондемир, Гияс ад-Дин б. Хумам ад-Дин ал-Хусейни. *Муизз ал-ансаб*. анализ перевода Ш. Вохидова. Алма-аты: 2006